УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 07 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	*1*
Хуралдааны товч тэмдэглэл:	*2-7*
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	*8-56*

1.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/	*9*
2.Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийг томилох тухай асуудал	*9-34*
3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	*34-45*
4.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	*45-56*

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 07 дугаар сарын 01-ний өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 100 гишүүн хүрэлцэн ирж, 79.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 18 минутад Төрийн ордны "Их хуралдай" танхимд эхлэв.[1]

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Х.Баттулга, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Д.Бум-Очир, Х.Ганхуяг, Л.Оюун-Эрдэнэ, Р.Сэддорж;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Баасанжаргал, Д.Батбаяр, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Ч.Лодойсамбуу.

Хоцорсон: Ж.Батжаргал-01 минут, Ц.Даваасүрэн-13 минут, Б.Жавхлан-01 минут, Д.Жаргалсайхан-03 минут, З.Мэндсайхан-50 минут, Б.Найдалаа-2 цаг 01 минут, Б.Пунсалмаа-12 минут, Б.Тулга-18 минут, Б.Хэрлэн-02 минут, Д.Цогтбаатар-25 минут, Б.Энхбаяр-2 цаг 34 минут.

Нэг."Хянан шалгах түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Ж.Батжаргал "Хянан шалгах түр хороо байгуулах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлаас авсан завсарлагын хугацаа дууссан**,** завсарлагын хугацааг дахин ажлын 3 өдрөөр сунгах тухай мэдэгдэв. Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт уг асуудлаар ажлын 3 өдрийн завсарлага өгөв./14:23/

Хоёр.Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч Э.Анар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын

[1] Хуралдаан даргалагч ирцийг танилцуулах үед 2 гишүүн ирцэд нэмэгдсэн.

хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчөөр томилуулах тухай саналыг Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, томилох асуудлыг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар нар танилцуулав.

Танилцуулга болон санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, О.Цогтгэрэл, О.Номинчимэг, Г.Ганбаатар, Ц.Баатархүү, С.Эрдэнэболд, Да.Цогтбаатар, Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, С.Цэнгүүн, Ж.Галбадрах, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчид нэр дэвшигч Э.Анар нар хариулж, тайлбар хийв.

Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийг томилох тухай асуудлаас Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин ажлын 2 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт уг асуудлаар ажлын 1 өдрийн завсарлага өгөв./15:32/

Гурав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл,* ***эцсийн хэлэлцүүлэг****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх Л.Мөнхзул, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, мөн газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, шинжээч Э.Цэрэнбат, Б.Баянжаргал, Г.Анхбаяр, ахлах мэргэжилтэн Д.Одонтуяа, Г.Мишээл, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Б.Батжаргал, мөн газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын ахлах мэргэжилтэн З.Пунцагцэрэн, А.Уртнасан, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны Ерөнхийлөгч Э.Тамир, мөн холбооны орон тооны бус дэд Ерөнхийлөгч Б.Алтанхуяг, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга Э.Энхжаргал, Санхүү, эдийн засгийн их сургуулийн багш, судлаач Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Хүний, хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, зөвлөх Б.Мажигсүрэн, референт Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, С.Эрдэнэбат, Д.Энхтүвшин, П.Наранбаяр нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга

Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т "Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно" гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./16:30/

Дөрөв.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл */Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан,* ***анхны хэлэлцүүлэг/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ж.Бямбадулам, Хуулийн газрын дарга Ш.Хишигсүрэн, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Б.Хатантуул, мөн газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, референт Б.Бадралт нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай, М.Ганхүлэг, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

С.Бямбацогт: Байнгын хорооноос хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжих нь зүйтэй гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 76
Татгалзсан: 34
Бүгд: 110
69.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Гурав дахь асуудал буюу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал/

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Нэг.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 2 ба 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.

Тайлбар: Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлээс чөлөөлөгдөх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 31
Бүгд: 110
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар:

/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгасан санал/

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 79
Татгалзсан: 31
Бүгд: 110
71.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар

өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 84
Татгалзсан: 26
Бүгд: 110
76.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2/Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

С.Бямбацогт: 1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 83
Татгалзсан: 27
Бүгд: 110
75.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Бусад.Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 1996 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Д.Батбаяр нарын урилгаар Төв аймгийн Баянхангай сумын ерөнхий боловсролын сургуулийн $12^{а}$ ангийн багш, сурагчид, Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суралцдаг оюутан, сурагчид,

Дархан-Уул аймгийн Хонгор сумын ерөнхий боловсролын 14 дүгээр сургуулийн 1986 оны 8[a] ангийн төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 22 минут үргэлжилж, 126 гишүүнээс 113 гишүүн хүрэлцэн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр 17 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.БЯМБАДУЛАМ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 07 дугаар сарын 01-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 18 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүдийнхээ өглөөний амгалан, өдрийн амгаланг айлтгая. 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн чуулганы хуралдааны ирц ирвэл зохих 126 гишүүнээс 96 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 76.2 хувийн ирцтэй тул чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

ТББХ сая хуралдаж дуусаад гишүүд орж ирж байна. Гишүүддээ мэдээлэл өгье. 7 хоногийн тов дараалалд тусгагдсан хэлэлцэх асуудлын тухай.

Уул уурхайн зарим төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 6 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар уг төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хойшлуулсан тул нэгдсэн хуралдааны хэлэлцэх эсэх асуудлаас хасагдсан.

Ирцийн мэдээллийг танилцуулъя. Өнөө өглөөний эртэч өнөөдрийн чуулганы хуралдаанд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Мэндбаярын Мандхай, Одонгийн Цогтгэрэл, Аюушийн Ариунзаяа, Одсүрэнгийн Номинчимэг нарын гишүүд хамгийн эртэч гишүүд болсон байна аа. Зочин танилцуулъя.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар дараах 4 асуудлыг хэлэлцэнэ.

1.Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

2.Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох тухай асуудлыг хэлэлцэнэ.

3.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

4.Хөгжлийн бодлого төлөвлөлтийн түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна аа.

Зочин танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд, Цэвэгдоржийн Туваан, Далайн Батбаяр нарын урилгаар Төв аймгийн Баянхангай сумын ЕБС-ийн 12 А ангийн багш, сурагчид болон АНУ-д суралцдаг Монгол оюутнууд Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Төрийн ордонтой танилцаж байгаа та бүхэндээ Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл */Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү нарын 35 гишүүн 2025.11.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/*

С.Бямбацогт: Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 6 дугаар сарын 26-ны өдөр ажлын 2 өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Батжаргал дарга бүлгийн дарга.

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая аа. Уг хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн чуулган дээрээс манай бүлэг ажлын 2 хоногийн завсарлага олгогдсон. Энэ завсарлагын хугацааг Их Хурлын чуулганы Дэгийн тухай хуулийн 12.1-д заасны дагуу ажлын 3 хоногоор сунгаж өгнө үү гэж хүсэлт гаргасан. Энэ асуудлыг шийдэж өгнө үү гэж хүсэж байна.

С.Бямбацогт: МАН-ын бүлгээс завсарлагын хугацаа сунгах албан бичиг ирсэн байна. Батжаргал даргын гарын үсэгтэй. 12.1-ийг үндэслэн 3 хоног сунгах мөн сая саналаа хэллээ. Үүнийг үндэслэн ажлын 3 хоногийн завсарлага өглөө.

14.23 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр.Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгчийг томилох тухай асуудал

Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийг томилох тухай асуудлыг хэлэлцэнэ. Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч томилох саналыг Монгол банкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

С.Наранцогт: Эрхэм Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр томилуулах санал өргөн мэдүүлэх тухай. Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлж байна аа.

Анар нь 1984 онд Улаанбаатар хотод төрсөн. 1992-2001 онд нийслэлийн 10 жилийн 1 дүгээр дунд сургууль, 2001-2004 онд Япон улсын Хакухо ахлах сургууль, 2004-2008 онд Япон Улсын Хакухо Их Сургуулийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн бөгөөд 2007-2008 онд АНУ-ын Индианагийн их сургууль, 2014-2015

онд АНУ-ын Колумбийн их сургуульд тус тус суралцаж Эдийн засгийн бодлогын удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Англи, япон хэлтэй.

Анар нь 2011-2013 онд Монгол банкны Валют эдийн засгийн газрын гадаад нөөцийн хэлтсийн нөөцийн мэргэжилтэн, 2013-2016 онд Монгол банкны Хяналт шалгалтын газрын Зайнаас хяналт тавих хэлтсийн хянан шалгагч, 2016-2017 онд Монгол банкны Төлбөр тооцоо бүртгэлийн газрын захирал, 2017-2026 онд Монгол банкны Төлбөр тооцооны газрын захирлаар ажилласан туршлагатай бөгөөд 2026 оноос Монгол банкны Төлбөрийн систем технологийн газрын захирлаар ажиллаж байна аа.

Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Э.Анарыг томилуулах саналыг өргөн мэдүүлэхдээ түүний эдийн засаг, банк санхүү, удирдлагын мэдлэг мэргэшлийн ур чадвар, мэргэжлийн ёс зүй, ажлын дадлага туршлагыг харгалзан үзсэн болно оо. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгчид баярлалаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан танилцуулна аа. Таныг индэрт урьж байна.

Б.Жавхлан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төв банкны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол банкны Ерөнхийлөгч Санжаагийн Наранцогт өөрийн бүрэн эрхийн хүрээнд Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Энхболдын Анарыг томилуулахаар нэрийг нь дэвшүүлсэн бөгөөд нэр дэвшигч Анар Эдийн засгийн байнгын хорооны нэр дэвших тухай хүсэлтийн загвар батлах тухай 2024 оны 3 дугаар тогтоолын дагуу өөрийн танилцуулга холбогдох бусад баримт бичгийг бүрдүүлж Эдийн засгийн байнгын хороонд ирүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны Дэгийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 6 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулах сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхланг томилсон.

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай Байнгын хорооны 4 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 121 дүгээр зүйлийн 121.3 дахь хэсгийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 16 гишүүн товыг хойшлуулах тухай хүсэлтээ Байнгын хороонд ирүүлсэн тул уг хүсэлтийг хэлэлцээд нэр дэвшигчийн сонсголыг 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр явуулахаар товлосон. Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай Байнгын хорооны 7 дугаар тогтоолыг баталсан.

Эдийн засгийн байнгын хорооноос 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан нэр дэвшигчийн сонсголд оролцогч ажиглагчаар нийт 16 иргэн бүртгүүлж, иргэн Амар, Баасандорж, Бүдбазар, Галцог, Зоригтбаяр, Хонгор, Эрдэнэмөнх нар нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсан болно оо.

Мөн нэр дэвшигчийн сонсголд Улсын Их Хурлын гишүүн Анар, Баатархүү, Батболд, Батнайрамдал, Батсүмбэрэл, Батчимэг, Булгантуяа, Бямбасүрэн, Ганхуяг, Жавхлан, Заяаболд, Золжаргал, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Мэндсайхан, Одбаяр, Пунсалмаа, Сайнзориг, Соронзонболд, Ундраа, Уянга, Үүрийнтуяа, Цогтбаатар, Цэнгүүн, Энх-Амгалан, Эрдэнэбат нарын гишүүд оролцлоо.

Нэр дэвшигчийн сонсгол явагдаж дууссаны дараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлийн 133.1 дэх хэсэгт заасны дагуу нэр дэвшигчийн сонсголд оролцсон Улсын Их Хурлын гишүүд хаалттай хуралдаж, Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшигчийн сонсголын тайланг гаргасан байна.

Байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх сонсголын тайланг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг гарган танилцуулж байна.

Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн орон тоо сул, дэд ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан байхад зөвхөн нэг санал өргөн мэдүүлсэн талаар Монгол банкны Ерөнхийлөгч Наранцогтоос тодруулаад нэр дэвшигчээс шалгуур шаардлага хангахгүй байгаа арилжааны банкнуудад авах арга хэмжээ, банкны хяналт шалгалтууд, банкны хяналт зохицуулалтыг хэрхэн сайжруулах талаар үйлчилгээ, зээлийн мэдээллийн сангийн тогтолцоог өөрчлөх, нэг удаагийн хар жагсаалтаас гаргах боломжийг судлах эсэх талаар. Мөн арилжааны банкнууддаа үйл ажиллагаанд бодитой хяналт тавьж, иргэдэд ээлтэй санаачилгатай бодлого хэрэгжүүлэх чиглэлээр ямар ажил хийх талаар Улсын Их Хурлын гишүүн Очирбат Эдийн засгийн өсөлт өндөр боловч инфляц буурахгүй. Иргэдийн худалдан авах чадвар муудаж байгаа нөхцөлд мөнгөний бодлогоор эдийн засгийг хэрхэн тогтворжуулж, уул уурхайгаас хамааралтай бүтцийг төрөлжүүлэхэд Монгол банк ямар үүрэг гүйцэтгэх талаар мөнгөний бодлогыг цаашид ямар зарчмаар хэрэгжүүлж бодлогын хүүгээр дамжуулан инфляцыг хязгаарлахаас гадна арилжааны банкнуудын зээлийн хүү санхүүгийн зуучлалыг хэрхэн сайжруулах талаар Монгол банкнаас хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн үр дүнг хэрхэн үнэлж цаашид үр өгөөжийг нь хэрхэн сайжруулах талаар мөн төрөөс төрөлжсөн банк мөн төрөөс төрөлжсөн банкнууд тухайлбал орон сууцжуулалтын банк байгуулах бодлогыг дэмжиж байгаа эсэх. Энэ банкны салбарын өрсөлдөөн санхүүгийн тогтолцоонд ямар нөлөө үзүүлэх талаар.

Улсын Их Хурлын гишүүн М.Мандхай салбарын бус хүмүүсийг удирдах албан тушаалд олноор томилж, мэргэжлийн боловсон хүчнийг гаргаж байгаа асуудалд ямар байр суурьтай байгаа, байгууллагын мэргэжлийн боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах, шатлан дэвших тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр ямар арга хэмжээ авах талаар арилжааны банкны эцсийн өмчлөгчид даатгалын салбарт давхар хөрөнгө оруулж үйл ажиллагаа явуулж байгаа нь санхүүгийн тогтолцооны эрсдэлийг нэмэгдүүлж байгаа эсэх. Банк болон даатгалын салбарын үйл ажиллагааг олон улсын жишгийн дагуу илүү бие даасан байдлаар хөгжүүлэх энэ чиглэлээр ямар зохицуулалт, хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх талаар нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлсэн болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар Энхболдын Анарыг Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид томилуулах талаар санал хураалт явуулах үед хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонсгол, сонсголын тайланг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

С.Бямбацогт: Жавхлан даргад баярлалаа. Чуулганы нэгдсэн хуралдааны танхимд нэр дэвшигч Энхболдын Анар хүрэлцэн ирсэн байна. Эрх бүхий албан тушаалтны санал, байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Пүрэвдаваа гишүүнээр тасаллаа. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ. Үг асуулт хамтдаа шүү.

М.Мандхай: Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалд нэр дэвшиж байгаа Анарыг дэмжиж үг хэлэх гэж байна. Тэргүүн дэд ерөнхийлөгчийн ер нь албан тушаал зөвхөн энэ байгууллагын удирдах албан тушаал биш гэдгийг би байнгын хороон дээр ч гэсэн бас хэлсэн. Хэн нэгэн одоо гаднын хөрөнгө оруулалтын банк ч гэдэг юм уу, санхүү дээр ажиллаж байсан ийм туршлагатай хүн сонгон шалгаруулалтад орж ирээд Монголын нөхцөлийг мэдэхгүй. Монголын дотоодын бас банкны нөхцөлийг мэдэхгүй, хүлээн зөвшөөрөгдөөгүй дотооддоо ийм хүн болгон энэ албан тушаалд очих нь өөрөө зохимжгүй юмаа. Тэгэхээр энэ дотоодын салбар тэр дундаа Төв банкны системийг таньж мэдсэн, мэргэжлийн салбартаа 15 жил ажилласан. Ялангуяа энэ хараат бус байгууллагын институцийн хувьд энэ өндөр хариуцлагатай албан тушаал дээр илүү салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн бас энэ институцийнхээ ой санамжийг мэддэг, бас энэ өөрийнхөө ажилчдынхаа дунд хүлээн зөвшөөрөгдсөн меритийн зарчмыг ийм хангасан ийм чадвартай боловсон хүчин байх ёстой гэж харж байгаа.

Тэгэхээр энэ хэн байхаас илүүтэй энэ салбартаа өөрөө багаас нь эхлээд мэргэжилтнээс эхлээд дээшээгээ одоо ингэж ажиллаж байгаа 15 жил ажилласан хүн бол байх нь маш зохимжтой гэж харж байгаа. Тийм учраас энд илүү энэ банк санхүүгийн системийн найдвартай ажиллагаа, иргэд болон бизнесийн санхүүгийн итгэлцлийг хангаж чадах, энэ төлбөр тооцооны төвийг нэвтрүүлж байсан харилцагчдын энэ эрх ашиг, санхүүгийн тогтвортой байдлыг хангаж ажиллаж байсан ийм туршлагатай хүн өөрөө болох нь маш зүйтэй юмаа. Тийм болохоор би одоо яг энэ Тэргүүн дэд ерөнхийлөгчид дэвшиж байгаа Анарыг дэмжих нь зүйтэй гэсэн байр суурьтай үг хэллээ.

С.Бямбацогт: Мандхай гишүүн үг хэллээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

О.Цогтгэрэл: Монгол банкны ерөнхийлөгч байна. Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшигч байна. Нэр дэвшигч нь Төлбөрийн системийн газрын захирлаар ажиллаж байсан хүн учраас би бас нэг асуулт асууя, тодруулга авъя аа. Энэ бас олон нийтэд ч хамаатай зүйл байгаад байна.

Олон улсын хэвлэлд гарснаар Файненшл Таймс сонинд гарснаар Монгол Улсын нэр бүхий 2 банк дайныг санхүүжүүлэх үйл ажиллагааны төлбөр тооцоонд оролцсон. Энэ нь би яах вэ олон нийтэд гарчихсан мэдээлэл учраас асууж байгаа юм шүү. Дайныг санхүүжүүлэх үйл ажиллагаанд тэр санхүүжилтийг бэлэн мөнгө хувиргах угаах энэ үйл ажиллагаанд удаа дараа оролцсон. Ийм учраас Монголын 2 банканд Европын холбооны зүгээс санкц тавих асуудал яригдаж байгаа гэдэг мэдээлэл олон улсын банканд олон улсын мэдээлэл дээр гарсан. Энэ ер нь яг ямар учиртай, ямар үйл явдал болоод байна вэ?

Одоо үндсэндээ бид нар энэ сайн сайхан зүйл ярьж байдаг наана чинь нөгөө хар данс олон олон зүйл чинь аль хэзээний хаалга тоншоод ороод ирчихсэн байгаа юм биш биз дээ. Энэ мэдээллийг тодорхой хэмжээнд ярьж болох түвшинд нь энэ Монгол банкны Ерөнхийлөгч болоод тэр тусмаа энэ дэд ерөнхийлөгчид дэвшиж байгаа хүн чинь Төлбөрийн системийн асуудал хариуцсан ажил хийж байсан юм байна. Таны ажил чиг үүрэгтэй нь хамаарах уу? Энэ чинь шалгадаг барьдаг наана цаана миний сонссоноор хэдэн 100 сая долларын асуудал, удаа дараагийн гүйлгээ, олон зүйл тэр хэвлэл мэдээллийн юм тодорхой бичигдсэн байна лээ. Тэгэхээр энэн дээр тодорхой байр суурь хариулт өгөөч? Монгол банкны Ерөнхийлөгч хариулт өгөөч, нэр дэвшигч одоо хийж байгаа ажил үүргийнхээ чиг үүргээр энд чинь ажлын хариуцлага асуудал энэ дээр байна уу? Энэ улс оронд яг ямар үр дагавар нь юу болж гарах юм, одоо үйл явц нь ямар байгаа юм. Энэ тухай мэдээлэл өгөөч. Энэ бол бас тийм ердийн биш мэдээлэл хэвлэлд гарсан шүү.

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгч хариулъя.

С.Наранцогт: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Таны ярьж байгаа энэ мөнгө угаах дайныг терроризм санхүү терроризмийг санхүүжүүлэх асуудал бол маш чухал асуудал, ноцтой асуудал. Энэ дээр бол Төв банк зохицуулагчийн үүднээс дүрэм журмын хувьд нэлээн чанд мөрдүүлэх чиглэлийг арилжааны банкнуудад өгч ажиллаж байгаа.

Миний хувьд энэ Ерөнхийлөгчөөр томилогдсоноос хойш 2 удаа албан мэдэгдэл, тодорхой чиглэл 2 удаа уулзалт хийж банкнуудад бол энэ дээр Төв банк маш хатуу зарчим барьж ажиллана гэдэг энэ шаардлагыг хүргүүлж ажиллаж байгаа. Таны асууж байгаа 2 банк гээд байгаа нь бид нарт албан ёсоор захидал юм ирээгүй, мэдэгдэл ирээгүй. Бид нар энэ мэдээг гарангуут Европын холбоотой холбогдож энэ ямар учиртай, юу болоод байна, яагаад энэ асуудал яригдав аа, яагаад бид нарт албан ёсны мэдээлэл ирүүлээгүй вэ гэдэг асуудал яригдсан. Хариулт юу гэж байна вэ гэхээр танай бол яах вэ банкнуудтай холбоотой 2022 оноос хийгдсэн гадаад гүйлгээ тэр дундаа ОХУ-тай энэ хоригийг тойрч орсон байж магадгүй гүйлгээнүүд дээр нэлээд ажиллаж байгаа. Нэг банкны асуудал яригдаж байна. Энэ нь танай банкны систем санхүүгийн системд чинь нөлөө үзүүлэхүйц тийм зүйл үр дагаваргүй учраас бид нар та нарт албан ёсоор мэдэгдэл өгөөгүй гэсэн ийм тайлбарыг ирүүлсэн. Өнөөдрийн болтол манай Төв банкны хувьд энэ албан ёсны мэдэгдэл ирээгүй байна. Ийм нөхцөл байдалтай байгаа.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Төлбөрийн системийн газрын захирлаар ажиллаж байсан нэр дэвшигч бас саяын асуултад гүйцээгээд хариулах нь зүйтэй байх. Та бол яах вэ ажил үүргийнхээ чиг үүргийн дагуу ч юм уу тодорхойгүй хариулт өгч байна л даа.

Энэ бол тодорхой болоод зарим банкан дээр чинь санкцын асуудал чинь аль хэзээний тавигдаад та нарт мэдээлэл ирээгүй биш эхэлчихсэн асуудлууд энэний цаана явж байгаа. Их наядаар гарах мөнгийг 2, 3 жилийн хугацаанд удаа дараа угаасан, бэлнээр гаргасан олон олон асуудал оролцогчтой асуудал, энэ бол ноцтой асуудал шүү. Энэ бол үнэхээр энэ асуудал энэ түвшиндээ яригдах юм бол Монгол банкны Ерөнхийлөгчийн түвшний ажил үүргийг нь, хариуцлагын түвшний чиг үүргийг нь томоохон асуудал энэний цаана яригдах байх шүү гэдгийг бас хэлье.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Номинчимэг: Монголбанкны...

С.Бямбацогт: Уучлаарай. Энэ Анар нэр дэвшигч хариулъя. Сая асуултад хариулт авъя гэж байна. 4 дүгээр микрофон индрийн.

Э.Анар: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Сая яг Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн яг хэвлэлд бол мэдээлэл гарсан. Монгол Улсын нэг банк гэдэг мэдээлэл гарсан. Яг тухайлсан банкны нэрийг одоогоор ирүүлээгүй байгаа. Миний хувьд 2016 оноос хойш Төлбөр тооцооны газрын захирлаар одоо хүртэл ажиллаж байна. Миний яг одоогийн чиг үүргийн хүрээнд дотоодын төлбөр тооцоо, яг гадаад төлбөр тооцоо бол яг миний чиг үүрэгт бол хамааралгүй. Энэ нь өөрөө гадаад улсын гэрээ контракт тухайн сүлжээгээрээ дамжаад явдаг зохицуулалт нь бол ийм байгаа. Төв банкны хувьд мэдээж мөнгө угаахтай холбоотой, мөнгө угаасан байж болзошгүй энэ гүйлгээ сэжигтэй гүйлгээг Санхүүгийн мэдээллийн алба болон одоо банкны хяналт шалгалт дээрээ бид мөнгө угаах дээрээ угаахыг хянах энэ чиглэлийн хэлтэс чиг үүргээр банкнуудтайгаа комплайнсынх нь зүгээс бол одоо...

С.Бямбацогт: Гүйцээчих үү. 4 дүгээр микрофон.

Э.Анар: Тийм болохоор яг одоогийн гишүүний асуусанчлан яг тухайлсан банкны нэр, яг ийм асуудалтай гэдэг албан ёсны мэдэгдэл Төв банкан дээр ирээгүй байгаад байгаа.

С.Бямбацогт: Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

О.Номинчимэг: Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Яг энэ салбарын хүн, мэргэжлийн хүн. Энэ салбартаа ажиллаж байгаа бас Монгол Улсын банкнуудын төлбөр тооцооллын систем олон улсын түвшний болгож ингэж хөгжихөд хувь нэмрээ оруулсан хүн гэж би хардаг. Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн чиг үүргийн маш чухал хэсэг нь бол хянан шалгалтын чиг үүрэг байдаг. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкнууд хууль тогтоомж Монгол банкнаас гаргасан энэ дүрэм журмыг хэрхэн сайн биелүүлж байна вэ гэдэг дээр хянан шалгалтыг хийдэг маш том чиг үүрэгтэй. Тэгээд Өргөдлийн байнгын хороон дээр иргэдээс энэ банкнуудтай холбоотой, үйл ажиллагаатай холбоотой зөндөө олон өргөдөл ирдэг. Тэгээд би бас танд нэг үг даймаар байна. Та хэрвээ сонгогдох юм бол энэ асуудал дээр анхаарч өгөөрэй гэж хэлмээр байна.

2021 онд Улсын Их Хурлаас баталсан Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай

хууль одоо хэрэгжиж байгаа. Тэгээд энэ хуулиар бол зээл олгож байгаа хадгаламж хийж байгаа банкнуудын үйл ажиллагаатай хэрэглэгчийн буюу санхүүгийн хэрэглэгчийн иргэдийн энэ эрхийг хамгаалах ингээд нэг заалтууд орсон байгаа юм. Тэгээд ер нь бол ингээд манай Монгол Улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах тал дээр нэлээдгүй ажиллагаа хийх ч хууль эрх зүйн орчныг нь сайжруулахгүй бол үнэндээ бодит байдал дээр зөвхөн банкны салбар гэхгүй энэ тэнцвэргүй байгаа иргэний хууль дээр ч гэсэн бид нар энийг дүн шинжилгээ хийж байхдаа хамгийн тулгамдсан асуудал хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлаар аль аль салбар дээр анхаарах ёстой байна аа гээд.

Тэгээд тэрний нэг бол яг энэ хуулийн 12.4-д заасан энэ хугацаатай хадгаламжийн гэрээг тохиролцсон хугацаанаас өмнө хадгалуулагчийн хүсэлтээр цуцлах эсхүл зарлагын гүйлгээ хийх тохиолдолд хадгалуулсан хугацаанаас нь хамааруулан хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулна аа гэсэн ийм заалт байдаг. Гэхдээ энэ бодит амьдрал дээр арилжааны банкнууд иргэдтэй хадгаламжийн гэрээ хийхдээ хэзээ ч ийм нөхцөлийг оруулдаггүй. Хугацаанаасаа өмнө цуцлах юм бол хугацаагүй хадгаламжтай адилхан дүнгээр хүүг нь боддог юм байна. Тэгээд энэ бол хууль эрх зүйн зохицуулалтын хувьд та 12 сар хадгаламж өгөөд 10 сарын дараа, 11 сарын дараа үнэхээр зайлшгүй хэрэгцээ гараад хадгаламжаа цуцлах тохиолдолд хугацаанаасаа хамаараад тэр хугацаагүй хадгаламжаас арай өндөр хүү гэрээгээрээ тохирч болмоор байгаа юм. Ийм л заалтыг уг нь энэ хуульд оруулсан. Гэтэл арилжааны банкнууд нэг талт стандарт гэрээг хэрэглэгчдэд тулгадаг учраас энэ заалт ерөөсөө хэрэгжихгүй байгаа талаар иргэдийн өргөдөл гомдол ирж байгаа.

Та Монголбанкны дэд ерөнхийлөгчийн хувьд манай Монгол банканд Монгол Улсад байгаа банкны системийг эрүүлжүүлэх, илүү тэнцвэртэй болгох, сайжруулах тиймээ эрсдэлээс хамгаалах олон ажлын хажуугаар энэ иргэдийн эрх ашгийг хамгаалах, банкнууд энэ хууль тогтоомжоо хэрэгжүүлж байгаа эсэх дээр маш сайн хяналт шалгалт хийж ажиллаарай гэж хэлмээр байна.

С.Бямбацогт: Үг хэллээ. Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Нэр дэвшигч Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгч гэдэг яг юу хийдэг албан тушаал юм бэ гээд жоохон сонирхлоо. Та чинь бас нэлээн чухал чухал чиг үүрэгтэй хүн байна шүү дээ.

1 дүгээрт, Монгол банкныхаа Ерөнхийлөгчийг орлодог юм байна.

2 дугаарт нь мөнгөний бодлого боловсруулах ялангуяа мөнгөний бодлогын хүү чиглэл дээр ажиллах ёстой юм байна.

3 дугаарт нь энэ банкны салбаруудын энэ хяналт дээр ажиллах ёстой юм байна. Тэгээд тэр зөвлөлийн гишүүн гээд.

Тэгэхээр таны намтар дотор 2011 оноос хойш та энэ салбарт 15 жил ажиллаж байгаа юм байна. Сүүлийн үеийн энэ ханш уналт ялангуяа 2016 оноос хойш Монгол төгрөгийн ханш гадаад валюттай харьцах ханш 82 хувиар унасан байна. Би сая ингээд тооцоо хийгээд үзлээ. Та энэ дотор явж л байсан хүний нэг байна л даа. Монгол банк Төв банк Засгийн газрын кассын үүрэг гүйцэтгэж байхад бас та тэрэн дотор нь явж л байсан хүн юм байна шүү дээ. Өнөөдөр энэ байгаа нөхцөл байдлаа

хар. Монгол түмний амьдрал энэ үнийн өсөлт яаж галзуурч, хүмүүсийн амьдрал яаж доройтож байгааг. Тэгээд ямар нүүрээрээ одоо ингээд энэ дотор нь ийм олон жил ажиллачхаад эргээд энэ тэргүүн дэдэд нь орж ирж байдаг юм.

2016 оноос хойш энэ 80 ам.долларын эсрэг 80 хувь сулраад байгаа мөнгөний ханшийг та энэ салбарт ажиллаж байгаа хүний хувьд яаж тогтворжуулах юм, ямар бодлого баримтлах юм, мөнгөний нийлүүлэлтээр мөнгөнийхөө нийлүүлэлтийг ямар замаар зохицуулж, яаж инфляцыг хянах юм. Энэ тал дээр би таны бодлыг сонсъё гэж бодож байна. Дараа нь би тодруулга авъя.

С.Бямбацогт: Нэр дэвшигч Анар хариулъя. Индрийн 4 дүгээр микрофон.

Э.Анар: Гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад инфляцын түвшин бол 11.2 хувьтай хамгийн сүүлийн байдлаар тоо байгаа. Энэ тооны бараг 5, 6 нэгж хувь нь 1, 2 бүтээгдэхүүнээс хамааралтай. Энэ бүтээгдэхүүн нь өөрсдөө өөрөө болохоор нийлүүлэлтийн гаралтай бүтээгдэхүүн болоод инфляцад нэлээн том хэмжээний тийм дарамт учруулах ийм нөхцөл байдлыг үүсгээд байна. Бид нарын хувьд яах вэ одоо хамгийн гол өндөр нөлөө үзүүлээд байгаа мах, махан бүтээгдэхүүн одоо бараг 4.4 нэгж хувийг манай инфляцын энэ багц дотор байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нарын зүгээс ерөнхийдөө яг Төв банкны мөнгөний бодлогын хувьд яг маханд шууд нөлөөлөх боломжийн хувьд харьцангуй хомс. Тэгэхээр бид нарын хувьд ер нь яах ёстой вэ гэдгийг бол энэ 8, 9 сард бол жилийн дунджаас харахад махны үнэ жоохон буудаг яг энэ хүлээлт байна. Дээрээс нь шинэ ногооны хүлээлт бол бас үнийн хүлээлт буух болов уу гэсэн тийм хүлээлттэй байгаа. Тэгэхээр зэрэг инфляц бол мэдээж тодорхой хэмжээний 1, 2 нэгж хувиар 3 дугаар улирлын сүүл хүртэл буух болов уу гэсэн хүлээлт бид нарын хувьд байна аа.

Мэдээж ханштай холбоотой та асуулаа. Ханш бол яг тогтдог зарчим нь эрэлт нийлүүлэлтээсээ хамааралтай тогтож байгаа. Төв банкны хувьд бол харьцангуй ханшинд шууд одоо их огцом хэлбэлзэхгүй бол огцом оролцох тийм зорилгогүй. Аль болох зах зээлийн зарчмаар нь эрэлт нийлүүлэлтийнх нь байдлаар нь одоо бид ханшийг ингээд тогтоогоод явах ийм чиглэлтэй байгаа. Тэгэхээр зэрэг ханшин дээр харьцангуй бид нарын хувьд гадаад валютын улсын нөөц бол түүхэн дээд 7.4, 7.5 гэсэн тэрбум долларын хэмжээтэй байгаа энэ үед ханш бол харьцангуй тогтвортой байх болов уу гэсэн хүлээлтийг бас бид байна. Гол бид нарт тулгамдаж байгаа асуудал бол яалт ч үгүй инфляцтай холбоотой. Ялангуяа 1, 2 бүтээгдэхүүнтэй холбоотойгоор ингээд нэлээн инфляц өндөр байгаад байгаа ийм асуудлууд байгаа. За баярлалаа.

С.Бямбацогт: Ганбаатар гишүүн тодруулъя. Гомбын Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Үгүй яах вэ энэ ханшийн үнийн өсөлт гээд ярихлаар нэг мах зах яриад л байх юм. Яах вэ үнийн өсөлт энэ ханшинд инфляцад монгол хүний хэрэглээ мах өндөртэй махны энэ үнийн өсөлт нөлөөлж байгаа нь үнэн. Монгол банкны зүгээс цаашдаа энэ монгол төгрөгийн тогтвортой байдлыг хангах, дээрээс нь энэ ханшийг мөнгөнийхөө нийлүүлэлт дээр яаж цаашдаа бодлого явуулах юм бэ л гэдэг л би асуулт асуугаад байгаа юм л даа. Хэтэрхий их бэлэн мөнгө зах зээл рүү та нар өнгөрсөн хугацаанд яваад наад монгол төгрөгөө хар л даа. Монгол төгрөгийн үнэ цэн, монгол хүний үнэ цэн 2 гэж нэг юм байхгүй болчихлоо шүү дээ. Тэгээд би энэ

талаас нь ямар бодлого явуулах юм гэж асуугаад байна. Тэрнээс биш инфляцад нөлөөлж байгаа мах зах яриагүй байна шүү дээ. Тэр инфляцад нөлөөлж байгаа хүчин зүйл нь мөн үү мөн. Алив эсвэл Наранцогт захирал та өөрөө хариулаадах. Дээрээс нь Наранцогт захирал ч гэсэн та одоо Улсын Их Хурлаас сонгогддог албан тушаалтан цаашдаа энэ дээр анхаарч ажиллах...

С.Бямбацогт: Индрийн 4 Наранцогт Ерөнхийлөгч.

С.Наранцогт: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Таны ярьж байгаа асуудлууд бид нарын суурь асуудал мөн. 2016 оноос хойш энэ бол 2013 оноос үнэ тогтворжуулах хөтөлбөр тэрнээс хойш тодорхой хагас төсвийн шинжтэй үйл ажиллагаа ипотекийн хөтөлбөр гээд ингээд Төв банкнаас мөнгө хэвлэх ийм үйл ажиллагаа энд асар их нөлөө үүсгэсэн. Энэ өөрөө мөнгө үржих процессоор, мөнгө үржих сувгуудаар ингэж нэмэгдэж бас зах зээл дээрх мөнгө мөнгөний нийлүүлэлтүүдийг нэмэгдүүлсэн ийм нөлөө байгаа.

Тэрнээс гадна зүгээр Монгол Улсын хувьд эдийн засгийн суурь бүтэц нь өөрөө юутай холбоотой байна вэ гэхлээр бид нар экспортлогч улс орон. Тэгээд экспортын орлого нэмэгдээд ирэхээр энэ экспортын орлого гаднаас орж ирээд төгрөг болоод ингээд энэ бэлтгэн нийлүүлэгч болоод энэ компаниудын дансан дахь мөнгө нэмэгдээд он гарснаар жишээлбэл экспортын орлого маань 78 хувь нь нэмэгдээд ирэхээр...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Индрийн 4.

С.Наранцогт: Энэ нийлүүлэлт нь ингээд 26 хувь нэмэгдэж байгаа юм. Тэгэхлээр энэ нийлүүлэлтийг л бид нар чиглэлийг яаж өөрчлөх вэ гэдэг асуудал байгаа юм.

1 дүгээрт, Төв банк ерөөсөө хагас төсвийн үйл ажиллагаа явуулах ёсгүй. Ингээд Төв банкны хуулийн өөрчлөлтөд өгчихсөн.

2 дугаарт, ингээд экспорт нэмэгдээд илүүдэл мөнгө гараад ирсэн тохиолдолд ирээдүйд баялаг бүтээх тэр салбар луу хэрхэн хөшүүрэгдэх вэ.

3 дугаарт, энэ мөнгийг яаж шингээх вэ гэхлээр хөгжиж байгаа орнууд хөрөнгийн зах зээл Засгийн газрын бондын зах мөнгөний зах энэ сувгуудаар ингэж шингээж аваад хэрэглэгчдийн импортын бүтээгдэхүүн болоод хэрэглээ рүү ордоггүй болж байж инфляц хөөрөгдөхгүй байгаа юм. Гэтэл өнөөдөр яаж байна вэ гэхээр энэ дэд бүтцүүдээ хөгжүүлэх талаар огт анхаарал тавиад Төв банк, Засгийн газар бүгдээрээ оролцож ажиллаагүй учраас зөвхөн Төв банкны үнэт цаасаар л Төв банк өөрийнхөө ажлыг чадан ядан хийгээд Төв банкны үнэт цаасны хэмжээ ингээд нэмэгдчихээд байгаа юм. Энэнээс одоо өөр инструмент байхгүй. Тэгэхээр дунд хугацааны бодлогын хөтөлбөр эхний ээлжид оруулсан...

С.Бямбацогт: Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя. Үг хэлнэ, үг хэлж болно.

Ц.Баатархүү: Би үг хэлчихье дээ. Байнгын хороон дээр асуусан. Монголбанк энэ Монголын мөнгөний бодлого, инфляц эдийн засгийн эргэлтийг хариуцаж байдаг хамгийн чухал байгууллага. Өнөөдөр Монголын хөгжлийн систем эвдэрсэн байна.

Төрийн институц эдийн засгийн бүтэц 2 бие биеийнхээ муу талыг дэмждэг хавдрын эс шиг бие биеэ тэжээдэг систем болсон. Монголд орж байгаа орлого маш цөөхөн үүд хаалгаар ордог орлогын бүтэц нь цөөхөн. Уул уурхайн бүтээгдэхүүн уул уурхайн бүтээгдэхүүн дотроо зэс, алт, нүүрс. Төсвөө энүүгээр бүрдүүлдэг. Уул уурхайн баялгаа гадагш нь түүхий эдээ гаргасан орлогыг хуваарилагч нь Засгийн газар. Дэмжигч хамжигч нь Монгол банк болж хувирсан. Хэн мэдээлэлд ойр энэ орлого, хуваарилалт хуваарилалтад ойрхон байгаа нь энэ түлхүүрийн төлөө өрсөлддөг болсон. Гацалтын тойрогт орсон. Монголын хувираа эрхлэгч бизнес эрхлэгчид өсөж өндийж экспортлогч болох маш хүнд байна.

1 дүгээрт, төрийн өмчийн компаниудтай өрсөлдөнө. Дараа нь энэ арилжааны банкны энэ өндөр хүүтэй зээлийг аваад татвараа төлөөд, тэгээд ашгаа гаргаж ажиллах боломж үнэхээр байхгүй байна аа. Тэгэхээр Тэргүүн дэд ерөнхийлөгч Монгол банканд ажиллаж байхдаа энэ урт мөнгө буюу урт хугацаатай бага хүүтэй зээлийн орчин дэд бүтцийг хийж амжаагүй байна аа. Хөрөнгө оруулалтын зориулалтын банкны хуулийг нь гаргасан боловч хөрөнгө оруулалтын банк ажилладаггүй, хууль нь хэрэгждэггүй, хөрөнгө оруулалт байхгүй учраас бүх жижиг дунд бизнес эрхлэгч нар хувираа бизнес эрхлэгч нар энэ өндөр хүүтэй зээлийн дараа ашгаа хийж чадахгүй байгаа учраас үүд хаалгаа барихад хүрч байна аа. Ийм учраас энэ Хөрөнгө оруулалтын банкны хуулийг амилуулж хэрэгжүүлэх тал дээр 1 дүгээрт анхаарах ёстой гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт нь энэ банкны засаглалыг ил тод болгох системийн хэмжээний нөлөө бүхий 5 банк олон нийтэд хувьцаагаа гаргахдаа нэг 5-10-хан хувийг гаргасан, хэлбэрийн төдий гаргасан. Энэ олон нийтэд нээлттэй болгож засаглалыг тунгалаг болгох энэ ажлыг зайлшгүй үргэлжлүүлэх ёстой шүү гэсэн ийм 2 саналыг хэлье ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Үндэсний аюулгүй байдлын тулгуур бол эдийн засгийн аюулгүй байдал. Бид нар үндэсний аюулгүй байдал дээр энэ чиглэлээр маш олон тунхаглал гаргасан. 1994 он, 2010 оны аюулгүй байдлын үзэл баримтлал дээр. Тэгэхдээ энийг ерөөсөө мөрдөхгүй байгаа. Манай улс маш сүртэй нэртэй урт хугацааны бодлогын бичиг баримтууд хийдэг атлаа түүнийгээ явцын бодлогын бичиг баримтууд руу тусгах дээр асар маруухан сул. Тэгээд ямар сайд ирнэ, ямар одоо удирдлага ирнэ тэр хүний улс төрчийн харизм, хувийн дүгнэлт, тойрон хүрээлэгчдийн хандлагаас бодлогууд тогтвортой биш байдлаар үргэлжлээд явдаг. Мэдээж эдийн засгийн аюулгүй байдлын гол ноён нуруу авч явдаг тэр институц бол Төв банк. Төв банкны удирдах бүрэлдэхүүнд ажиллана гэдэг бол мэдээж одоо хууль дээр байгаа инфляцыг бууруулах, мөнгөний бодлого, макро эдийн засгийг удирдах энэ зүйл дээр анхаарахаас илүүтэйгээр цаанаа байгаа Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын амьд халуун дархлаа болсон тэр эдийн засгийн аюулгүй байдлыг яаж тордож хамгаалах вэ гэдэг ойлголт байгаа.

Тэгэхээр эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг та яаж үнэлж дүгнэж байгаа вэ гэдгээ хэдүүлээ энэ удаагийн тэмдэглэл үлдээх зайлшгүй шаардлагатай. Бид нар ирээдүй цаг дээр маш олон зүйлийг ярьдаг. Асуудал дээр бол амжилт бүтээлээр бол эзэн олонтой шүү дээ. Алдаа завхрал бол их өнчин эзэнгүй, бүгдээрээ тангараг өргөсөн хүмүүс. Тэгэхээр өнөөдрийн эдийн засгийн нөхцөл байдлыг та яг юу гэж

үнэлж байгаа чинь их сонирхолтой байна. Эндээс чинь асуултаас чинь хамаарч тодруулах зүйлс гарах байх нэг.

Хоёрдугаарх, цаасан дээр бид нар мундаг амжилт гаргаад байна аа гэдэг. Нэг хүнд оногдох ДНБ-ний өсөлтийн тухай ярьдаг. Гэхдээ өнөөдөр яг бодит байдал дээр иргэд ядууралдаа бүүр живчихсэн, нийт өмчийн 70 хувь нь төртэй хамааралтай, дарга тойрсон бүлэглэл бол хангалуун амьдарч болоод байдаг, амьдралаас тасарч болоод байдаг, жирийн иргэд асар хүнд нөхцөл байдалд байна аа. Ядуурал, ядуурал дагасан олон нийгмийн сүүдрүүд. Тэгэхээр энэ дээр бол та яг ер нь ямар арга хэмжээ авбал зөв гэж яг энэ манлайллын хувьд үзэж байгаа вэ? Энэ 2 асуултад та хариулахгүй юу?

С.Бямбацогт: Хариулъя. Нэр дэвшигч Анар хариулъя. Индрийн 4.

Э.Анар: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал мэдээж та бүхэн сайн мэдэж байгаа. Эрсдэлтэй, тодорхойгүй байдал маш одоо ялангуяа геополитикийн тодорхойгүй байдлууд бол өндөр ийм нөхцөл байдалтай байна. Мөн дотоодын эрэлт, дотоодын гаралтай инфляцад нөлөөлж байгаа бүтээгдэхүүнүүдийн үнэ ханш өссөн, хүнсний үнэ ханш өссөн, урьд хожид байгаагүйгээр 70, 80 хувиар төмс хүнсний ногоо жишээ нь өссөн байдалтай ийм нөхцөлтэй байна.

Дээрээс нь хойд хөршийн геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор шатахууны үнэ өсөх бас магадлал байгаа юм болов уу гэсэн ийм хүлээлтүүдтэй ийм л одоо тодорхойгүй нөхцөл байдал нэлээн харагдаж байна аа л гэж үзэж байна. Тэгэхээр зэрэг энэ дээр Төв банкны зүгээс ер нь яаж ямар бодлого барьж явах ёстой вэ гэдгийг сая Мөнгөний бодлогын хорооны хурал дээр танилцуулсан. Ер нь бол нэлээн мөнгөний бодлогын чанга ийм байдал хэвээрээ явах нь ээ гэдэг энэ мессежүүдийг ерөнхийдөө Төв банкны зүгээс өгсөн. Тэгэхээр зэрэг яалт ч үгүй одоо энэ тодорхойгүй байдал энэ одоо Монгол Улсын эдийн засаг, бүс нутгийн эдийн засагт бас тодорхой хувиар нөлөө байна аа гэсэн ийм хүлээлтүүд байна аа.

2 дугаар асуулт дээр болохоор зэрэг мэдээж Төв банкны зүгээс бол яг чиглээд тодорхой одоо юу гэх юм секторт бол тодорхой хэмжээний юунууд оруулаад явах боломжууд байгаа. Тэгэхдээ бас Төв банкны хуулиараа хязгаарлагдсан ийм зохицуулалтууд байгаа. Тэгэхээр зэрэг бидний зүгээс аль болох л эдийн засгийг солонгоруулах, экспорт, импортыг дэмжих, нэмэгдүүлэх, илүү гадаад валютын улсын нөөцөө нэмэгдүүлэх энэ чиглэл рүү бол гол түлхүү анхаарч ажиллана аа гэсэн бодолтой байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Эрдэнэболд гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэболд: Ер нь алба авч байгаа ямар ч хүмүүс бусдын сүүдэрт биш өөрийнхөө итгэлээр ажиллаарай гэж хэлмээр байна. Яах вэ би сая асуусан асуултдаа юу гэж хүсэж байсан гэхлээрээ энэ одоо эдийн засгийн энэ хүндрэл нөхцөл байдлууд чинь нөгөө л авлига, нөгөө л хулгай, нөгөө л ашиг сонирхлоос болдог оо. Цоорхой хувин руу бид нар одоо дээрээс нь юм нэмж хийгээд байгаа юм шиг юм болж байгаа. Тэр Төв банкны удирдлагын зүгээс Ерөнхийлөгч нь сууж байна. Банктай холбоотой олон шүүмжүүд өмнөх жилүүдэд гардаг байсан. Тэрэн дотор ажиллаж байгаа хүмүүсийн ашиг сонирхлын асуудлууд яригддаг байсан. Тэгээд энэ бүх зүйлүүдийг таслан зогсооход одоо эх оронч зүрх сэтгэл гаргаж Анар нэр

дэвшигчээ ажиллаарай. Цаана сууж байгаа хүнтэйгээ хамт энэний төлөө ажиллаж, цаад хүнээ ч гэсэн шахаж аливаа ашиг сонирхлоос ангид байгаарай.

2 дугаарт Геополитик гэдэг зүйл чинь өөрөө тодорхойгүй байдал нь тодорхой байгаа учраас энэ бүх зүйлийг битгий шалтаглаж яриарай.

С.Бямбацогт: Үг хэллээ. Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Да.Цогтбаатар: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Тэгээд Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ гээд би энэ Улсын Их Хурлынхандаа хандаж хэлэх гэсэн юм. Та нар энэ хүнийг томилчоод мөнгөний ханшаа бусад валютын эсрэг буюу төгрөг юань, долларын эсрэг үнийг нь нэмэгдүүлж чадахгүй ээ. Инфляцаа нам доор түвшинд барьж чадахгүй ээ. Тэгээд одоо энийг бодохоор энэ гишүүдийнх нь бусад энэ дэмжих гээд байгаа гишүүдийн өмнөөс би бол жинхэнээсээ яс янгинаж байгаа юм. Зовлонг нь монголчууд нийтээрээ эдлээд, ямбыг нь нэг гэр бүл эдлээд байж бас болохгүй ээ. Энэ бол ёстой шударга ёсонд нийцэхгүй ээ.

Өчигдөр нэр дэвшигчээс асуусан асуултад хариулсан байдал тэгээд тэр Төрийн банк нь өөрөө Төрийн банкны хувьцаа эзэмшигч нь хадгаламж эзэмшигчийнхээ эрх ашгийг хамгаалах байгууллага буюу хадгаламжийн даатгалын корпорацын энэ хувьцаа энэ нөгөө хяналтад нь байдаг байж болохгүй. Энэ бол наад захын энэ банкны ойлголтгүй, суурь ойлголтгүй ийм хүн л гэдгийг харуулаад байгаа юм. Тэгээд энэ Анар дарга аа, та уучлаарай өмнөх ажлаа л хий, битгий юун тушаал дэвших вэ. Би бол бараг таныг нэрээ татчихаасай гэж бодож байгаа. Тэгвэл бас монголчууд ч баярлах байх. Таны хийх ажил махны үнийг буулгах биш эсрэгээрээ монгол төгрөг үнэтэй байх ч гэдэг чинь Монгол банкны хийх ажил шүү гэдгийг одоо бас хэлье.

Тэгээд энэ манай энэ цагаан намын улаан намын цагаан байрны хэдэн гишүүд байгаа. Ёстой амаа олохгүй долоож байна зарим нь бол. Тэгээд энэ даргаа шүтдэг нам л даа манай энэ улаан намынхан. Тэгээд одоо дарга нь үх гэвэл дагаад үхэх юм шиг байгаа юм манай энэ нэг хэдэн гишүүд тийм гишүүд байх шиг байгаа юм. Тэгээд би бол энэ гишүүдийнхээ өмнөөс ёстой бүүр хамаг юм улайгаад байна л гэдэг шиг юм болох гээд байгаа юм. Одоо энэ үр дүн гэж нэг юм гарна хэсэг хугацааны дараа. Тэгээд ингээд үр дүнгээ харахад бид нар өндөр инфляцтай, төгрөг нь үнэгүй, худалдан авах чадамж султай, худалдан авах чадамж муутай ийм мөнгөн тэмдэгттэй Монгол Улс болно шүү гэдгийг анхааараасай гэж бодож байна. Тэгээд инфляц буурахгүй, төгрөг нь улам сулраад байх юм бол та нар сонгогчийнхоо өмнө очиж Монгол банкан дээр бид нар тийм томилгоо хийсэн гэдгээ яаж тайлбарлаж хэлэх юм. Би бол одоо гайхаж байгаа.

Тэгээд төгсгөлд нь Ерөнхийлөгчийгөө орлох эрхтэй гээд байгаа юм. Одоо ажиллаж байгаа Дэд ерөнхийлөгч чинь нэг арилжааны банкны гүйцэтгэх удирдлагыг томилох зөвшөөрөл олгохдоо Монгол банкны тухай хуулиа зөрчиж байгаад авлигын шинж чанартай үйлдэл хийгээд, гүйцэтгэх удирдлагынх нь томилох зөвшөөрлийг хийгээд өгөөд явуулчхаж байгаа юм. Нөгөө Ерөнхийлөгчийгөө байхгүй байхад. Тэгэхээр та нар Ерөнхийлөгчийгөө орлож байна гээд Монгол Улсыгаа хорлоод байж болохгүй ээ. Хууль зөрчөөд байж болохгүй ээ гэдгийг анхааруулж хэлэх гэсэн юм.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Мэнд хүргэе ээ. Монгол банкны Тэргүүн дэд ерөнхийлөгчид нэр дэвшүүлж байгаа Монгол банкны Ерөнхийлөгчөөс асууя. Нэр дэвшигчийг бол дэмжиж байна. Энэ банкны үйл ажиллагаатайгаа холбоотойгоор асуулт байгаа юм аа. Ер нь энэ арилжааны банкнууд ялангуяа хувийн банкнуудын эзэд, ТУЗ-ийн гишүүд, эзэмшигч нар банкны үйл ажиллагаа явуулахын зэрэгцээ барилга барьдаг, ТҮЦ ажиллуулдаг, хоолны газар ажиллуулдаг, сургууль ажиллуулдаг гээд саналууд гомдлууд их байгаад байгаа. Энэ дээр хяналт шалгалтууд явуулж энэ байдлыг засаж залруулах тал дээр Монгол банк ер нь ямар санаачилга гаргаж ажиллаж байна аа? Банкнуудад иргэд бизнес эрхлэгчид өөрсдөө бизнесийн санаагаа бичээд ТЭЗҮ-ээ гаргаад өгчихөөр нөгөөдхийг нь ажил болгоод өөрсдөө хийгээд явчихдаг гэдэг ийм гомдол саналууд байдаг юм байна лээ. Энийг та ер нь юу гэж бодож байна аа?

Саяхан аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр 6 хувийн хүүтэй зээлийг төрөөс олгосон. Энэ зээлтэй холбоотой гомдол саналууд өнөө хэр байгаа. А банкны эзэн өөрийнхөө харьяаны мэдлийн Б аялал жуулчлалын компанидаа бага хүүтэй зээл гаргаж өгч байгаа талаар аялал жуулчлалын компаниуд гомдлоо ирүүлж байгаа. Энэ мэтчилэнгээр банкны эзэд өөр олон салбарт ажил хийгээд, Монгол Улсыг банкчид удирдаж байгаа байдлыг засан залруулах тал дээр Монгол банкны удирдлагууд ямар ажил хийж байна? Үүнийг яаж засах ёстой гэж үзэж байна вэ? Энэ дээр асуулт хариулт авъя аа.

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгч хариулъя.

С.Наранцогт: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Таны ярьж байгаа асуудал туйлын чухал зөв асуудал. Тийм учраас Монгол банк энэ дээр ямар асуудал яригдаж байна вэ гэхээр энэ хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрхэн ухаалаг, үр дүнтэй болгох вэ гээд зохицуулалтууд бол байгаа. Ер нь хамаарал бүхий этгээдийн харилцан хамаарал бүхий этгээдүүд банкны үйл ажиллагаанд зээл авах энэ банкны үйл ажиллагаанд оролцох энэ хязгаарлалтууд байгаа. Мэдээж энийг сайжруулах шаардлагууд бий. Энийг хэрхэн үр дүнтэй зүгээр болгох вэ гэвэл бид нар орчин үеийн технологи мэдээллийг сайжруулах журмаар л бий болгоно. Тийм учраас одоо манай өнөөдрийн байдал дээр юу болж байна вэ гэхээр бид нарын хийгээд эхэлсэн ажилд та юу хийж байна вэ гэж асуусан.

Төв банканд арилжааны банкнууд энэ нэг бүхэл бүтэн хэлтэс гараад цаасан тайлан юмыг ингээд хэлтэс болгож ингэж өгдөг. Өөрөөр хэлбэл өөрсдөө боловсруулж бид нар бол одоо энийг энэнээс больё гэж байгаа. Ер нь бол энэ биг дата буюу их өгөгдөлд суурилсан банкнуудын кор систем Төв банктай холбогдоод энэ сардаа нэг ирж байгаа тайлан дээр нэг хүн суугаад анализ хийдэг биш энэ бодит цагийн горимд Төв банкны хяналтын тогтолцоо хиймэл оюун ухаан орчин үеийн технологи дээр сууж байгын бодит цагийн горимд хяналт тавигдаж байх ёстой. Ингэж байж яг үр дүн гарна. Үнэхээр тэр улсууд энэ харилцаа хамаарал бүхий улсууд оролцоод байна уу. Энэ дээр нөлөөлөлд оролцоод байна уу. Ингэхгүйгээр бол одоо банкнууд өөрсдөө нэг тайлан бэлдээд, компайл хийгээд тэрийгээ Төв банканд авчирч өгдөг нөгөөдхийг нь манайхан ажиллаад.

Тэгэхээр энэ тал талаас нь ажиллаж байгаа гэсэн үг. Тэгэхээр энийг бол одоо байгаа эрх зүйн зохицуулалт, журам юмаа үр дүнтэй бий болгож энэ хяналт тавих процессын үр дүнг сайжруулна гэсэн үг. Нэмээд шаардлагатай зохицуулалтыг бас чангаруулах ийм ажил хийх шаардлагатай. Энийг бас хийгээд явна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Монгол банкны Ерөнхийлөгчийг гаднаас томилсон нь их зөв байна гэж би хувьдаа бодож явж байгаа. Тийм учраас дотроо олон жил тогтвортой ажилласан хүнийг Тэргүүн дэд ерөнхийлөгчөөрөө нэр дэвшүүлж ажиллах гэж байгаа юм байх шиг байгаа юм. Ер нь саяын асуултын дагуу тэр арилжааны банкнуудын хяналт шалгалтуудыг сайн хийх ёстой юм шиг байгаа юм. Энэ дээр маш их эргэлзээ тээнэгэлзээ гомдол саналууд явдаг. Үүнийг анхаарч ажиллаарай. Монгол банканд дотоод хяналтын нэгж байдаг байх. Түүнийгээ гаднаас хөндлөнгөөс тавивал их зүгээр болов уу гэж санаагаа хэлж байна. Тэгээд Монгол банкны ажилд амжилт хүсье.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Нэр дэвшигч болон Монгол банкны удирдлага ирсэн дээр нэг бас нэг хэдэн асуулт асууя гэж бодож байна. Ер нь зүгээр Монгол Улс бас улсын төсвөөс гадна 2, 3 төсөвтэй гэдэг зүйл яриа гардаг. Хөгжлийн банкны төсвөө ч нэг хамаатуулж нэг авч үзээд л, ТӨК-иуд дээр ч гэсэн их наядаар хэмжигдэх хөрөнгө оруулалт болон урсгал зардлын зардлууд гарч байгаа юм. Би харин энэ дээр нэмээд нэг Монгол банкийг энэ харин төсөвтэй юм шиг 2 дахь төсөвтэй юм шиг явж байгаа нэг зүйл байгаа байхгүй юу. Монгол Улсад төрийн бүх байгууллага энд ганцхан Монгол банк ордоггүй. Төсвөө батлуулдаг ядаж төсвийн дээд хязгаараа батлуулдаг. Өнөөдөр Монгол банк энэ хараат бус бие даасан байдал ч гэдэг юм уу ерөнхий ийм халхавчин дор энэ зүйлүүд явж ирэхгүй байгаа. Зарим нь мэдээж энэ Монгол банкны хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зардлууд гарч байгааг би үгүйсгэхгүй. Тэгэхдээ ийм хяналтгүй энэ институцийг ер нь цаашдаа яах ёстой юм бэ гэдэг дээр би асуумаар байгаа юм.

Тэгэхээр энэ тухайн жилийн магадгүй урсгал зардлын төсвийн хязгаар орон тооны дээд хязгаарыг нь Улсын Их Хурал чинь тогтоогоод өгчхөж болдоггүй юм уу? Одоо алийн болгон энэ улс төрчдийн шахаануудыг авсан энэ хариуд нь ингээд Монгол банк ингэж дурааараа дургиж явах юм бэ? Энийгээ би одоо шийдэх ёстой гэж бодож байгаа. Тийм учраас энэ асуудал дээр Монгол банкны удирдлага ер нь ямар байр суурьтай байдаг юм хариулж өгөөч.

2 дугаарт энэ ОТ-н төлбөр тооцоог Монголын банкнуудаар гүйцэтгэх энэ боломж нөхцөл ер нь бүрдсэн үү? Анх энийг бас нэг Улсын Их Хурлаар тогтоол батлаад, Монгол банкаар дамжуулаад явах гэхээр бид хэдийн бас чадавх хүрэхгүй ийм зүйлүүд яриад байдаг байсан. Ер нь цаашдаа энэ төлбөр тооцоог Төв банк болон Монголын банкнуудаар дамжуулах энэ нөхцөл боломж нь ер нь юу гэж бодож байна? Монгол банкны удирдлага энийг бас нэг хариулж өгөөч.

Дээрээс нь энэ Засгийн газар энэ орон сууцтай холбоотой банк байгуулах Орон сууцын тухай хууль өргөн барьсан. ОУВС-гаас удаа дараа зөвлөмж өгдөг өө. Ипотекийн зээлийн санхүүжилтийг Монгол банкнаас салгаж Засгийн газар хариуцах

ёстой гэдэг. Ер нь цаашдаа Монгол банк энэ ипотекийн зээл дээр ямар бодлого зарчим баримтлах гэж байгаа вэ? Энийг бас нэг Монгол банкны удирдлага хариулж өгөөч.

За эргээд одоо ер нь Төв банкны энэ хууль эрх зүйн орчин энэ одоо ажил үүргээ гүйцэтгэхэд ер нь ямархуу байдлаар байна гэж ерөнхий дүгнэж байна. Энийг бас та нэг хэлээч. Дээрээс нь энэ зээлийн хүүг бууруулах гээд улиг болтлоо л ярилаа. Яг гавьсан юм алга. Мөнгөний нийлүүлэлт муу байна, томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлж чадахгүй байна, байгаа хөрөнгө оруулагчдаа тууж янз бүрээр шахаж хавчиж байна. Тэгээд нэг ганц 2 эхлүүлсэн энэ төсөлдөө хавчигдаад бусад том төслүүдээ хөдөлж чадахгүй байна, хөдөлгөж чадахгүй байна. Тэгэхээр энэ хэрэглэгчийн зээлийн...

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгч хариулъя 4.

С.Наранцогт: Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Монголбанкны төсвийг та хөндөж ярьж байна. Энийг бас ингээд Их Хурлын гишүүдийн түвшинд нэг яриад нэгдсэн ойлголтод хүрэх нь зөв байх аа. Энэ асуудал хөндөж байгааг бол би ойлгож байна. Ер нь зүгээр бид асуудлыг бүх цогцоор нь бодоод, олон улсын туршлага ижил төстэй улсуудын жишигт нийцүүлээд аль нь үр дүнтэй байгааг харгалзан үзэх ёстой. Ер нь бол дэлхийн Төв банкнуудын 90 хувь нь энэ төсөв нь бол ингэж парламентаар хянагддаггүй энэ ялангуяа мөнгөний бодлого хяналт шалгалтын чиглэлээр явагддаг энэ зардлууд бол энэ Төв банкны өөрийнх нь шийдээд явдаг. Төсвөөсөө бүрэн тусдаа байдаг ийм тогтолцоотой юм. Тэгээд энийг бол жишээнүүд аваад үзэх юм бол манайд ижил төстэй энэ Гүрж энэ инфляцыг нам доор түвшинд бий болгосон улсууд бол яг энэ тогтолцоон дээр явж байгаа. Яг Засгийн газрын талдаа хянуулдаг, төсвөө хянуулдаг хайпер инфляцад орчихсон бас тодорхой жишээнүүд байгаа.

Тийм учраас зүгээр энийг ингээд яг олон улсын экспортуудаар судалгаа хийлгээд Монгол Улсын хувьд аль нь зөв асуудал вэ, бид нар алинаараа явах вэ гэдэг зүйл байгаа. Энийгээ биднүүс нэг ярьж ойлголцоод нэг цогцоор нь авч үзэх нь зөв байх аа. Зүгээр ер нь хяналтын тогтолцоо байгаа юу гэвэл байгаа. Их Хурал өөрөө Монгол банкан дээр хяналт шалгалт хийх эрх зүй нь байна. Их Хурлаас томилсон хяналтын зөвлөлийн гишүүд ажиллаж байна. Их Хурлаас томилсон мөнгөний бодлогын зөвлөлийн гишүүдтэй. Миний хувь бодлыг асуух юм бол Монгол банкны засаглалыг сайжруулах эрх зүйн шинэчлэл шаардлагатай. Би энийг удаа дараа зарлаж байгаа. Одоо үндсэн суурь асуудлууд байна аа, энэ инфляц энэ төсөв мөнгөний уялдаа энэ төсвийн хагас төсвийн үйл ажиллагааг хязгаарлах эхний энэ зүйлүүдийг хийчхээд дараа нь энэ цогцоор нь Төв банкны засаглалыг сайжруулах асуудал яригдах ёстой.

Өөрөөр хэлбэл Төв банк ТУЗ-тэй болоод, ТУЗ-ийн засаглалыг нь зөв болгоод, ТУЗ-ийг нь Их Хурлаас томилоод, ТУЗ нь өөрөө төсвөө батлаад явбал яг олон улсын жишигт хөгжсөн орнуудын жишиг рүү орно. Тэгэхээр энэ дээр ийм бодолтой байгаа. Энэ дээр Төв банкны хууль дээр сайжруулж ялангуяа энэ төсөв засаглалтай холбоотой асуудлыг сайжруулах концепцыг миний хувьд бол байна. Энийгээ оруулж ирнэ гэсэн бодолтой байна. Мэдээж Их Хурлаас тодорхой ажлын хэсэг томилж нэлээн концессуудаа нэгтгэж байгаад орж ирэх ёстой гэж ингэж бодож байна аа.

2 дугаарт нь сүүлийн асуултын эхнээс нь санаад явъя. Та нараас сануулаарай. Ипотек гэсэн тиймээ. Ипотекийн энэ зөвхөн төрөөс хамаарсан 6 хувийн тогтолцоогоор ингээд яваад цаашдаа явахад маш хязгаарлагдмал аа. Тэгэхээр энийг бол бид нар зах зээлийн хэрэглэгчдээ тохирсон бүтээгдэхүүн, олон бүтээгдэхүүн гаргах, гаднын зах зээлээс яг зах зээлийн зарчмаар мөнгө татах урт хугацааны сангуудыг бий болгож ийшээ татан оруулах энэ механизмыг л бүрдүүлэх концепц л доо. Зүгээр яг банк яагаад байж байна вэ гэхлээр манай энэ ажлын хэсгийнхэн тайлбарлаад байгаа нь нөгөө хөрөнгө татах энэ банкнуудын үйл ажиллагаа явуулах агуулгаараа банк байхгүй бол энэ нөгөө үйл ажиллагааны хувьд хязгаарлалт үүснэ гээд байгаа юм. Төрийн өмчийн агентлагаасаа илүү.

Тэгэхээр бид нарын байр суурь нь бол эрсдэл нь хаана байна вэ гэхлээр үндсэндээ бас л засаглал дээр. Тэгэхээр төр давамгайлаад зүгээр төрөөс шууд удирдлага менежментийг нь томилоод байвал бас гажуудал үүсэх эрсдэл байгаа. Тийм учраас засаглалын хувьд бол бодлого нийлүүлэх үүднээсээ төр бол юу гэдэг юм нөгөө алтан хувьцаа юм уу Голден шэйртэй хөрөнгө оруулагчид өөрсдөө энэ удирдлага менежментээ аваад явдаг. Тэгээд энэ зах зээлийнхээ зарчимд явуулдаг ийм тогтолцоо руу орох нь туйлын зөв. Төв банкан дээр энэ авч явах нь буруу. Тийм учраас энийг ингээд шилжүүлэх ёстой гэсэн юу байгаа. ОТ-н...

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн үгүй хариулт хариултаа дуусгачихъя.

С.Наранцогт: Тэгээд ОТ-гоо асууж байна та. Валютын зохицуулалтын тухай хууль байгаа. Манай валютын зохицуулалтын тухай хууль бол бас нэлээн дээр гараад яг амьдрал дээр хэрэгжихэд бас нэлээн хүндрэлтэй, яг орчин үеийн цаг үедээ. Тэгээд энийг бид нар сайжруулах ёстой. Мэдээж хэрэг бид нар аль болох гаднын манай баялгийг ашиглаж байгаа тохиолдолд валютын орлого нэмэгдэх энэ чиглэл рүү гэхдээ хэрэгжихэд амьдрал дээр хэрэгжихэд хэрэгжихүйц ийм хууль эрх зүйн орчныг бий болгох ёстой. Яагаад гэвэл нөгөө том хэмжээний төсөл хэрэгжүүлэхэд заавал гаднын зээл, санхүүжилт босгох шаардлага болно. Тэгэхээр энийгээ буцаагаад төлнө өө гэдэг нь тэртээ тэргүй төлөх мөнгийг зүгээр Монголд оруулж ирээд буцаагаад төлөх нь банк санхүүгийнхээ хувьд ч тэр бусад ийм асуудлууд байгаа юмаа.

Тийм учраас энэ яах вэ өөрөө хөрөнгө оруулалтын гэрээгээр зохицуулагдаж байгаа Их Хурлын тогтоол гарсан учраас бид нар Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэдэг бичгийг болбол...

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн тодруулж асууя.

П.Сайнзориг: Би бол тэгэхээр Наранцогт дарга одоо ингээд шинэ удирдлагын багтай болж байна. Жоохон бүтээлчээр ажиллаасай гэж хүсэж байна. Монгол банк яах вэ бодлогын юуг одоо дээш, доош татаж байгаагаа л нэг зарлаад л байдаг. Яг дорвитой өнөөдөр Монгол Улсын бизнесийн эрх зүйн орчин дээр мөнгөний нийлүүлэлт болон тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг татах асуудал дээр танай салбар л угаасаа гацаана шүү дээ яг бодит. Тэгэхээр энийг одоо үнэндээ хэлэхэд зоригтойхон жоохон хөдөлгөмөөр байна аа. Тэгэхгүй ингээд банкны эзэд нь өөрсдөө өөр бизнес хийчихдэг, энэ ямар ч хяналтгүй бид бүүр хүлээн зөвшөөрөөд сурчихсан. За ингээд Монгол банканд байгаа олон хүмүүс угаасаа банк бус санхүү болон ХЗХ-той ломбард ажиллуулдаг. Ийм байдлаар явахаар энэ бизнесүүд чинь ерөөсөө хөгжихгүй байна аа. Тийм учраас Төв банкны энэ нэг

хуулийг өөрчлөх, Монгол банкны хуулийг өөрчлөх энэ асуудал дээр би хамтарч ажилламаар байна. Хурлын дарга үнэхээр чухал шаардлагатай хүмүүсээр нь ажлын хэсэг гарвал би ажлын хэсэгт бас орж ажиллая. Болдог бол ажилламаар байна. Бүх бизнесийн...

С.Бямбацогт: Нэг минутаа нэмээд асуултаа дуусгачихъя.

П.Сайнзориг: Тэгээд дээрээс нь одоо жишээ нь тендер худалдан авалтын ажиллагаан дээр төрийн сангаас мөнгө нь гардаггүй, одоо материалаа татмаар байдаг. Гүйцэтгэлээрээ гээд жоохон гацчихдаг энэ дээр ингээд фактингийн асуудлыг илүү их дэмжиж өгмөөр байгаа байхгүй юу. Энэ богинохон улиралтай энэ зүйлүүд дээр банк санхүүгийн салбар нь өөрөө тодорхой хэмжээнд дэмжиж ажиллаж байж энэ бүтээн байгуулалт чинь явна аа. Тийм учраас энэ Монголд бизнесийн орчныг сайжруулах ажлын байр бий болгох энэ ажил дээр би одоо Наранцогт дарга энэ Анар Тэргүүн дэд ерөнхийлөгч болох байх тиймээ. Энэ 2 хүн бас манлайлал үзүүлж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд хамтарч ажиллая гээд би бас саналыг тавьж байна аа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ юу. Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Энхтүвшин: Монгол банк бол ганцхан зорилготой. Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийн тогтвортой байдлыг хангах. Тэгээд энийг хангахын тулд бие даасан байж байж л хангах зорилготой. Тэгэхээр хууль дээр нь бас яг энэ бие даасан байдлыг нь хангах нөхцөлүүдийг нь заагаад өгчихсөн байдаг. Ялангуяа Засгийн газартай харьцах харилцаан дээр тодорхой заалтууд байдаг. Засгийн газраас Монгол банканд ямар нэгэн чиглэл өгч болохгүй, гэрээ хэлцэл хийж болохгүй, тодорхой хуульд заасан зүйлүүдээс бусад тохиолдолд тэгээд зээл олгож шууд болон шууд бусаар зээл олгож болохгүй, зээлийн өрийн бичгийг нь худалдаж авч болохгүй гэсэн ийм тодорхой хязгаарлалтууд байдаг. Тэгэхээр яах вэ өнгөрсөн хугацаанд энэ нь өөрөө яах вэ энэ Монгол банкны бас бие даасан байдалтай холбогдуулаад бусад Улсын Их Хурлаас томилдог бүтцүүдийн дэд ерөнхийлөгч нарыг бол томилдоггүй. Монгол банкны дэд ерөнхийлөгч нарыг томилдог. Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ бие даасан байдлыг хангах ийм зорилгоор энийг хийдэг байх аа гэж боддог. Тэгэхээр энэтэй холбоотойгоор энэ бие даасан байдал ер нь сүүлийн жилүүдэд алдагдаад байгаад өнгөрсөн хугацаанд бид нар зүгээр тоо хараад үзвэл үнэ тогтворжуулах хөтөлбөр гээд ийм төсвийн шинжтэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлж ирсэн.

Тэгэхээр яах вэ шинэ Ерөнхийлөгчийн хувьд бас энэ дээр нэлээн хатуу байр суурь илэрхийлнэ гэж байр суурь юу яг хуулийн хүрээнд энэ бие даасан байдлаа хадгална гэдэг байр сууриудаа илэрхийлж байсан. Тэгээд энэ дээр яах вэ энэтэй холбогдуулж нэг бүтэц байгаа. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл гээд Монгол банкны Төв банкны тухай хууль дээр байдаг. Тэгээд энэ байгууллага ерөөсөө дуугарахгүй, ажиллахгүй байгаад байгаа. Тэгэхээр энэ байгууллагын гол зорилго нь болохоор санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангана. Энэнтэй холбоотой эрсдэл үүсэхээр бол энэнээс хамгаалж сэргийлнэ гэсэн ийм үүрэг зорилготой бүтэц байдаг. Тэгээд энийг юу ерөөсөө энэ байдал ажиллахгүй байгаа харагдаад байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл энэ сая Сайнзориг гишүүн ч асууж байна. Төсөвтэй холбоотой 2, 3 төсөв ТӨК-аар дамжуулдаг, Хөгжлийн банкаар дамжуулдаг, тэгээд

дээр нь бүүр ингээд дахиад сая тусад нь гадаад зээлийн ашиглалтыг сайжруулах гээд жишээлбэл хууль ингээд баталж байна. Бие даасан байх ёстой бүтцүүд нь өөрөө Монгол банк нь ийм өмнөх хугацаанд төсвийн шинжтэй үйл ажиллагаануудыг ингээд санхүүжүүлээд хөтөлбөрүүдийг Засгийн газартайгаа нийлээд байсан. Монгол Банкны Ерөнхийлөгч нь бараг бүх Засгийн газрын хуралдаанд шахуу ингээд Засгийн газрын гишүүн шиг ингээд мэдээлэл сонсоод байж байдаг гэх мэтчилэнгээр гээд энэ санхүүгийн тогтолцоо маань өөрөө бие даасан байх ёстой бүтцүүд маань хоорондоо холилдоод байгаа учраас энэ тодорхой хэмжээнд эрсдэл үүсчхээд байна гэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ Тогтвортой байдлын зөвлөлийн талаар энийг одоо яаж ажиллах ёстой. Энэ бүтэц ажиллах шаардлага байгаа эсэх талаар Монгол банкны Ерөнхийлөгч болон Тэргүүн дэд ерөнхийлөгч нараас байр суурийг нь сонсъё оо. Баярлалаа.

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгч хариулъя.

С.Наранцогт: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Та маш чухал асуудлыг олж харсан байна аа. Энэ бол санхүүгийн тогтвортой байдал, макро орчны тогтвортой байдал Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үндсэн суурь. Энийг хангах нэг механизм бол Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл байгаа юм. Тэгэхээр энийг бол бид нар Монгол банкны хуулийн нөгөө шинэчилсэн найруулгыг оруулж ирэхдээ зайлшгүй шинэчлэх шаардлага байгаад байгаа юм. Зөв ажиллаж байгаа энэ байх ёстой механизм. Тэгэхдээ хэдүүлээ энийг Монгол Улсын орчинд тохируулах ёстой. Яг ний нуугүй одоо бодит байдлыг хэлэх юм бол энэ ингээд зөвлөлийн бүтцээс нь эхлүүлээд ярих ёстой. Манай Хадгаламж даатгалын корпорац бол зүгээр юу байхгүй юу ажиглагчаар суух бололцоотой байгууллага нэг зүгээр л хадгаламжийг даатгадаг тиймээ, одоо яг адилхан статустай сууж байна. Бусад орнуудын хувьд энэ зөвлөлийг Төв банк даргалдаг. Одоо бол ээлжилж ингэж даргалж удирдаад явдаг.

Өөрөөр хэлбэл яг нөгөө талдаа Сангийн сайд бол нөгөө Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын юу байдаг. Төв банк бол Улсын Их Хурлаас ч бас томилогдсон. Яг энэ дээр бас хууль дээр нэлээн тодорхой эрх мэдлийн зүйлүүдийг нь нарийвчилж өгөхгүй бол энэ механизм нэг тал руу хэлбийх ийм эрсдэлтэй байгаа юм бодит байдал нь. Тийм учраас энэ дээр бол миний хувьд хувьдаа энэ шинэчилсэн найруулга дээр оруулах концепц байна аа. Энэ ингэж л явах ёстой юм байна гэсэн концепц байна. Тэгээд энэ өөрөө ажиллаж байж энэ санхүүгийн тогтвортой байдлыг бий болгоход бол маш чухал механизм мөн. Баярлалаа.

С.Бямбацогт: Анар нэр дэвшигч хариулъя.

Э.Анар: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл бол одоо Монгол банк, Сангийн яам, СЗХ, Хадгаламжийн даатгалын корпорац гэсэн үндсэн 4 гишүүнчлэлтэй Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл бол үйл ажиллагаагаа явуулж байгаа. Яах вэ миний зүгээс миний харж байгаагаар энэ бол нэлээн тийм идэвхтэй ажиллах ёстой. Монгол Улсад санхүүгийн зах зээл дээр санхүүгийн байдал янз янзын юу гэдэг юм эрсдэл үүсэхээс өмнө, эрсдэлтэй үйл ажиллагаа болох ч гэх юм уу тэрнээс өмнө бид нар энд энэ дээр нэлээн тийм идэвхтэй ажиллах ёстой байх гэж үзэж байгаа. Ерөнхийлөгч сая дурдлаа. Гишүүнчлэлийн хувьд бас өөрчлөх шаардлага байгаа юу гэвэл байгаа юм шиг байгаа юм.

Төв банкны бүтцийн хувьд сая Наранцогт Ерөнхийлөгчийн хэлснээр газар хэлтсүүдийг нэлээн өөрчилсөн. Энэ дотор Санхүүгийн тогтвортой байдлын газар гэж тусгайлсан газар бодлогын газар бий болгосон. Энэ дотор нь ногоон зээл гэхээр макро хүртээмж шингэсэн одоо энэ...

С.Бямбацогт: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Баярлалаа. Сая нөгөө Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль гэж одоо юу хэлэлцэгдээд явж байгаа. Эцсийн хэлэлцүүлгийн шатандаа явж байгаа. Тэгээд энэнтэй холбогдуулж Банкны тухай хуульд өөрчлөлт оруулсан. Өөрөөр хэлбэл 36.1 дээр байдаг 20 хувийн 1 хувьцаа эзэмшигч болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн 20 хувийн шаардлага, 20 хувиас хэтрэхгүй гэсэн ийм шаардлага байдгийг гадаадын банканд оруулж юу хамаарахгүй байхаар ийм өөрчлөлт орсон байгаа. Тэгээд энэ нь цаашдаа бусад арилжааны ба дотоодын банкнууд энийг энэнтэй адилхан өөрчилье гэсэн бодол байгаа юу? Ер нь энэ тал дээр ямаршуу Монгол банкны бодлого байгаа вэ? Тийм Ерөнхийлөгчөөс асууж байна. Тийм баярлалаа.

С.Бямбацогт: Наранцогт Ерөнхийлөгч хариулъя.

С.Наранцогт: Тийм юм өргөн баригдсан байна лээ. Тэгээд бид бол нөгөө одоо бол гадаадын хөрөнгө оруулалт тэр тусмаа гаднын хөрөнгө оруулагчийг банкны сектор луу татах ийм бодлого Төв банкны зүгээс ч тэр, Засгийн газрын зүгээс ч ингээд нэгдсэн байр суурьтай байгаа. Тэгээд яах вэ нөгөө тандах судалгаа гэдэг шиг гаднын хөрөнгө оруулагчтай нэлээн уулзаж ингээд явахад бол банк өөрөө энэ регуляц өндөртэй, зардал өндөртэй ийм бизнес учраас энэ дээр ингээд гаднын зах зээл рүү жижиг хувьцаа эзэмшигчээр оролцох нь бол тэгээд эрсдэлтэй гэж үздэг ийм байр сууриуд нэлээн гарсан учраас ер нь зүгээр бид нар стратегийн хөрөнгө оруулагч татъя гэвэл тодорхой банк, тодорхой хөрөнгө оруулалт дээр бол ядаж нөгөө 51 хувь дээр байх ёстой юм байна гэж үзээд Банкны тухай хууль дээр өгсөн санал бол 51 хувь хүртэл, системийн банкийг нь болохоор 34 хувь хүртэл гэдэг ийм өөрчлөлтөө оруулаад явсан. Бид нар...

С.Бямбацогт: Зочин танилцуулъя. Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЕБС-ийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа та бүхэндээ төгсөгчдөдөө Улсын Их Хурлын нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Манай Отгонбаяр гишүүний найз нар уу, ах эгч нар юм шиг байна тиймээ. Сүхбаатар аймгийн 1996 оны төгсөгчид юм байна шүү. Манай Хуралдаан зохион байгуулах буруу тайлбарласан. За уучлаарай 10 насаар ахиулъя. Зарласанд уучлаарай. Отгонбаяр гишүүний маань төгсөлтийнхөн байна шүү. Багш нь бас явж байгаа юм байна аа.

Саруулсайханы Цэнгүүн гишүүн асуултаа асууя. Асуулт асууж, үг хэлнэ.

С.Цэнгүүн: Өдрийн мэнд хүргэе. Тэгээд ер нь нийтийн удирдах албан тушаалтныг томилохдоо нээлттэй өрсөлдөөнт зарчмыг зарчмаар сонгон шалгаруулалтаа л хийчихмээр байгаа юм. Тэгээд нээлттэй өрсөлдөөнт ийм сонгон шалгаруулалтыг зарлахаар мерит зарчмаараа явж байгаа хүмүүс нь дотроосоо нэрээ дэвшүүлж болно. Аль эсвэл гаднаас ур чадвар сайтай хүмүүс ч гэсэн нэрээ эрх тэгш одоо оруулаад, тэгээд өрсөлдөх боломж нь нээгдчих ийм байгаа юм л даа.

Тэгээд одоо үүсээд байгаа асуудал нь болохоороо Наранцогт Монгол банкны Ерөнхийлөгч маань нэг хүний нэрийг шууд ингээд ганцаарангаар нь оруулаад ирэхээр энэ нь өөрөө хаалттай томилгоо болчхоод байгаа юм үндсэн асуудал нь.

Тэгэхээр нөгөө шийдвэр гаргахад энэ чинь өөрөө хаалттай хүрээнд яваад байгаа учраас залуучууд маань өрсөлдөх боломж олдсонгүй шүү дээ гээд л бухимдал үүсээд байгаа юм л даа. Тэгэхээр ер нь Монгол Улсад хэн ч бай ямар ч албан тушаалд томилогдож болно. Тэр нь өөрөө өрсөлдөөнөөрөө ороод, сонгон шалгаруулалтад ороод явчхаж байгаа болохоор бид нар субъектив байдлаар хандах биш яг бодит байдлаар ур чадварууд дээр нь фокуслаад явах боломжийг нь л нээгээд өгчих юм бол хэн хэнээ нэр дэвшиж байгаа хүнийгээ хардаж сэрдээд байх хэрэггүй. Эсвэл тэр томилгоог хийж байгаа хүмүүсээ ч гэсэн хардаж сэрдээд байхгүйгээр энэ томилгоо маш зөв хийгдээд явах ийм боломж байгаа юм л даа.

Ер нь ингээд маш олон удаа давтагдаад байгаа учраас бид нар ер нь энэ томилгоо хийхдээ нэг хүний нэрийг хаалттайгаар оруулж ирэхээ болиод, ердөөсөө л нээлттэй сонгон шалгаруулалт дандаа зарлачихдаг байя л даа. Хүсэж байгаа хүмүүс нь нэрээ дэвшүүлээд өрсөлдөөд үзэг. Тэрэн дундаасаа сайн хүн нь гараад ирэг. Ингээд явчих юм бол хаа хаанаа ийм хардалт сэрдэлтгүй зөв томилгоонууд хийгдэх боломжтой. Нөгөө талдаа бүх хүнд боломжийг нь нээчихсэн эрх тэгш нэг ийм ардчилсан Монгол Улсын зарчмаар явмаар юм шиг харагдаад байгаа юм.

Тэгээд Наранцогт Ерөнхийлөгчөөс асуумаар байна. Дараагийн томилгоонууд дээрээ та нээлттэй сонгон шалгаруулалтаар ингээд томилгоонуудаа зарлаад, тэгээд дотроо жишээ нь нээлттэй байдлаар өрсөлдөөн үүсгэх боломж бий юу? Тэр тал дээр нь та анхаарч ажиллаж чадах уу гэж асууя.

С.Бямбацогт: Урьд нь чинь ерөөсөө ямар ч нөгөө нэр дэвшигчийн сонсгол, томилгооны сонсгол явуулдаггүй, сонсгол дээрээ санал хураадаггүй, байнгын хорооны санал хураадаггүй шууд л Их Хурал руу орж ирдэг байсан. Харин ч одоо бас нэлээн том дэвшил гарчихсан байгаа. Наранцогт Ерөнхийлөгч нэмээд хариулъя.

С.Наранцогт: Цэнгүүн гишүүний асуултад хариулъя. Таны энэ ярьж байгаа үндсэн зарчимтай би 100 хувь санал нэг байна аа. Ер нь энэ сонгон шалгаруулалтыг бид нар нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтын зарчмыг ер нь хэвшүүлэх нь зөв байгаа. Тийм учраас Монгол банкан дээр доод техникийн ажилтан доод төвшнүүдэд бол одоо шинээр ингээд томилгоо хийхэд бол сонгон шалгаруулалт хийгээд явж байгаа. Бид нар сонгон шалгаруулалтыг зарлаад эхний жишээлбэл бид нар сонгон шалгаруулалтын үр дүн гарсан. Үнэхээр бас чадалтай залуучууд орж ирж байна лээ. Эндээс бид нар бол томилгоо хийгээд явна.

Яг сая Их Хурлын дарга ч хэлсэн. Энэ Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч ингээд Тэргүүн дэд ерөнхийлөгчийн томилгооны хувьд бол яг ингээд хуульчилчихсан ерөнхий заалттай. Ингээд хуулийнхаа хүрээнд би эрх мэдлийнхээ хүрээнд оруулж ирж...

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулъя 4 дүгээр микрофон.

С.Наранцогт: Тэгээд бас танд нэг зүйлийг зүгээр бас ойлгох үүднээс ер нь энэ Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгчийн хувьд бол

техникийн ажилтан гэхээсээ аль арай илүү стратегийн чиг баримтлалыг барьж ажиллах түвшний ийм албан тушаал юм байгаа юм. Тийм учраас энэ дээр бол нөгөө зөвхөн юу гэдэг юм техникийн мэдлэг боловсролын үнэлгээгээр сонгон шалгаруулалт явуулах нь бас яг бүрэн дүүрэн нийцэх үү гэдэг асуудал бий. Ер нь тэгээд би түрүүний ярьж байсан энэ Төв банкны засаглалыг сайжруулах тухай Төв банкны хуулийн шинэчилсэн найруулгаар зайлшгүй хөндөх асуудлуудын нэг бол энэ мөн. Тийм учраас Төв банк одоо ТУЗ-тэй болох ёстой, Дэд ерөнхийлөгч юмнуудынх нь яг үндсэн шаардлагуудыг юу байх вэ. Энийг бас тодорхой хэмжээтэй...

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ алга байна. Равжихын Эрдэнэбүрэн гишүүн алга байна. Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ж.Галбадрах: Өдрийн мэнд хүргэе. Тэргүүн дэд ерөнхийлөгчид дэвшиж байгаа Анар нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Мэргэжлийн хүн байна. Мөн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн эксперт хүн гэдэг нь анкетаас нь харагдаж байна аа. Би бас хувиараа сагсан бөмбөгийг сонирхдог хүний хувьд Сагсан бөмбөгийн холбооны тэргүүн гэдгээр нь сайн мэддэг.

Ингээд миний асуултууд нэлээн олон хүнтэй давхардлаа. Тэгээд товч асууя. Хэрэгжүүлэх арга хэмжээний тухай өөрийнхөө анкетад бичихдээ инфляцыг Монгол банкны зорилтот түвшинд хадгална гэсэн байна аа. Энэ зорилтот түвшин гэдгийг энэ жил хэд байгаад хэд болчхов? Энэ алдсан уу яасан. 2028 он гэхэд инфляц ер нь ямар түвшинд хүргэх вэ гэдэг ийм зорилт тавьж байгаа та тодорхой тоо хэлж өгөөч ээ гэдгийг асуух гэж байна. Үүнийг хийхийн тулд ямар бодлого барих, ямар арга хэмжээ эн тэргүүнд авах вэ? Ер нь инфляцаа энэ жил бид нэлээн алдчихлаа гэж харж байгаа. Юмны үнэ тэнгэрт хадчихлаа. Ядуурал маань газар авч байна. Тэгээд Монголбанкнаас эд нар энэнтэй холбоотой нь энэ хатуу бодлого барих хэрэгтэй байгаа. Та энэ бодлогынхоо талаар товч танилцуулаач ээ гэж хүсэж байна.

Мөн гадаадын банк орж ирэх нөхцөл боломж хэр байдаг вэ? Монгол Улсад гадаадын банк оруулж ирэх талаар таны хувийн бодлыг бас сонсъё. Миний мэдэхээр Японоос лав Сүмитомо UFJ гэдэг банк орж ирж салбараа байгуулж нэлээн олон жил болж байгаад тэгээд буцаад гараад явсан. Энэ юунаас болсон юм бол оо гэдгийг та мэдэх бол хариулж өгөөч. Ялангуяа бид одоо Японоос хөрөнгө оруулалт татах тал дээр нэлээн та өөрөө Японд ахлах сургууль төгссөн, дээд сургууль төгссөн хүн юм байна. Тэгэхээр энэ тал дээр бас ямар зорилт дэвшүүлж байгаа вэ гэдгийг нь асууя.

Мөн одоо бид яг Орон сууцын санхүүжилтийн төрөлжсөн банкны тухай хуулийг Их Хурлаар оруулж ирээд бид одоо яг хэлэлцээд ингээд явж байна. Тэгэхээр энэ тал дээр энэ төрөлжсөн банк ингэж байгуулах ач холбогдлыг та хэлж өгөөч ээ гэсэн ийм асуултууд байна.

С.Бямбацогт: Анар нэр дэвшигч хариулъя.

Э.Анар: Гишүүний асуултад хариулъя.

Монголбанкны хувьд инфляцын энэ жилийн хувьд би түрүүн дурдсан. Яг одоо сүүлийн байдлаар бол 11.2 хувь байна. Энэнээс энэ 11.2-ын одоо 4.4 нь зөвхөн нэг бүтээгдэхүүн. Энэ 60 гараад 6.8 хувь нь 2, 3 бүтээгдэхүүнээс хамааралтай байна.

Тэгэхээр 2026 оны мөнгөний бодлогын үндсэн чиглэл дээрээ Төв банкны зорилтот суурь хүү бол 6 дээр нэмэх нь нэг нэмэх хасах 2 гэсэн 8 дээдэх нь 8, доод тал нь 4 гэсэн. Тэгэхээр энэ рэнжид байна аа гэж бид нар бодлогын хүрээнд төсөөлсөн. Яг нийлүүлэлтийн гаралтай энэ инфляцтай холбоотой энэ шокны энэ 4.4 нэмээд өөр бусад бүтээгдэхүүнээ ингээд яг одоо бид нарын төлөвлөснөөр ингээд яах юм бол уг нь зорилтот бүлэгт байхаар байх боломжууд байсан байна аа гэж бид нар дүгнэлтээс харахаар байгаа юм. Тэгэхдээ яах вэ мэдээж эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал өөрөө ийм байгаа үед бол бид нар бас мөнгөний бодлогоо хатуу бодлогоо хэвээр нь үргэлжлүүлэхээс өөр аргагүй нөхцөл байдалд байгаа. Тэгээд бас одоо 3 дугаар улирал, 4 дүгээр улирал руу бас жоохон инфляц жоохон буух болов уу гэсэн хүлээлт байгаа. Тэгэхдээ бид нарын хувьд бол бас яг шууд хэлэхэд эрт байна.

Та гаднын банк орж ирэх тал дээр асуусан. Гаднын банк оруулж ирэх тал дээр бол сүүлийн 1, 2 жилийн хугацаанд мэдээж энэ эдийн засгийн солонгоруулах байдалтай ч холбоотой, зээлийн хүүтэй ч холбоотой, урт хугацааны хөрөнгө оруулалт татахтай ч холбоотойгоор ер нь гаднын банк оруулж ирэх нь зөв юмаа гэсэн хувь хүний бодол бол байгаа. Тэгэхээр зэрэг энэ тал дээр Төв банкны зүгээс ч тэр, ер нь хууль эрх зүйн орчин ч гэсэн бид нар эргэж харах илүү жоохон нээлттэй болох энэ бодлогыг бид нар барих нь буруу биш байх аа гэж бодож байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ одоо юу гэдэг юм гаднын хөрөнгө оруулалт урт хугацаатай, бага хүүтэй хөрөнгө оруулалт орж ирснээрээ мэдээж бусад Монгол Улсын хүрэлцэхгүй байгаа бусад секторуудад бол энэ хөрөнгө оруулалт орох боломж бас байгаа болов уу гэсэн хүлээлт байгаа.

Тухайлсан улсын банк орж ирэх үү гэж тодруулж асуусан байна. Японы яах вэ сүүлийн үед бид нар Бүгд Найрамдах Солонгос Ард Улсын 2, 3 банк ерөнхийдөө санал тавьсан. Түүн дотроос бас нэлээн ажил хэрэг болоод дотоодын банкуудтай бас санамж бичгийн түвшинд зураад явж байгаа айлууд байгаа. Тэгэхээр энэ банкнууд маань орж ирснээрээ түрүүн дурдсан урт хугацаатай бага хүүтэй хөрөнгө оруулалт орж ирэх, дээрээс нь бас одоо тухайн өндөр хөгжсөн улсуудын банк санхүүгийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнүүд давхар орж ирэх тийм боломжууд бүрдэх юм байна аа гэсэн ийм хүлээлтүүд байгаа. Тэгэхээр зэрэг энэ тал дээр бас Төв банкны зүгээс илүү нээлттэй, илүү одоо ийм боломжийг эрэлхийлж ажиллана аа гэж бодож байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Гүйцээгээд хариулчихъя. Төрөлжсөн банк 4.

Э.Анар: Орон сууцын төрөлжсөн банкны хувьд бол ирэх намрын чуулганд өргөн барихаар хуулийн төсөл өргөн бариад байгаа. Тэгээд мэдээж Төв банкны зүгээс энэ банкны төрөлжсөн банкны энэ асуудал дээр дэмжих байр суурьтай байгаа. 2013 оноос эхлээд ингээд ипотекийн энэ хөтөлбөр Монгол Улсад ингээд хэрэгжээд эхлээд явсан. Төв банкны зүгээс бас тодорхой хувийн одоо 2018 он хүртэл тодорхой хувийн санхүүжилтийг энд хамт оруулаад явсан. 2018 оноос хойш бол энэ ипотекийн хөтөлбөрт Төв банкнаас оруулсан мөнгийг дахин орж ирсэн мөнгийг нь эргэж дахин ингэж оруулах байдлаар дахиж нэмж мөнгө оруулаагүй ингээд явж байгаа ийм байдалтай байгаа.

Тэгэхээр зэрэг ер нь яах вэ энэ хөтөлбөрөөс Төв банк бол зарчмын хувьд гарах нь зүйтэй. Энэ орон зайг энэ орон сууцын төрөлжсөн банк...

С.Бямбацогт: Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн асуултаа асууя алга байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ц.Идэрбат: Нэр дэвшигчийг дэмжиж байгаа. Тэгээд хэний хүү байх нь хамаагүй. Энэ аливаа гүйцэтгэх ажилд ялангуяа энэ мерит зарчмаар явна гэдэг бол ажил ер нь жоохон урагштай явахын урьд өмнөхөө цааш нь хэрэгжүүлээд явахын бодлогын залгамж халаа гэж хэрвээ байдаг бол энэ цаашаа үргэлжилж явахын эхлэл бол би мерит зарчим гэж ингэж боддог. Тэр ч утгаараа Монгол банканд ингээд 10 хэдэн жил ажиллаад ингээд дэвшээд ороод ирж байгаа юм байна. Тийм учраас дэмжиж байгаа.

Монгол банкныхнаас би одоо жил болгон мөнгөний бодлогын хүү бодлогын асуудал яригдах үед нэг асуудаг нэг 2, 3 үндсэн асуулт байгаад байгаа юм.

Нэгдүгээрт энэ тэтгэврийн зээлийн хүүг буулгах бололцоо бол байгаа гэдэг зүйлийг одоо үе үеийн Монгол Банкны Ерөнхийлөгч нар өнгөрсөн хугацаанд Мөнгөний бодлого батлагдах үеэр байнга ярьдаг. Тэгээд тэр нь ингээд нийгэмд хүлээлт үүсээд байдаг. Гэтэл яг амьдрал дээрээ бууж байгаа юм байгаад байдаггүй. Тэгэхээр энэ дээр Наранцогт Ерөнхийлөгч бас нэг тодорхой хариу хэлээч. Ямар ч эрсдэлгүй ийм зээл бол ийм буух бололцоотой гэдгийг Монгол банкныхан байнга одоо яриад байгаа шүү дээ. Тэгээд яг гүйцэтгэл дээрээ болохоор бууж өгөхгүй байгаад байдаг юм. Тэгэхээр таны хувьд энэ дээр ямар бодолтой байдаг вэ?

Хоёрдугаарт энэ ногоон зээлийн асуудлыг би бас нэг 3 жил ярьж байна. Тэгээд ногоон зээлийг энэ ялангуяа дэд бүтцэд холбогдчихсон аймгийн төвүүдийн гэр хороолол хашаандаа тэгж сайхан амьдрах тэр бололцоог бүрдүүлэхэд энэ ногоон зээлийн дэмжлэг их туйлын чухал байгаад байдаг юмаа. Тэгээд өмнө нь Лхагвасүрэн Ерөнхийлөгчийг байхад энэ 2 асуултыг асуухад ногоон зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлээд орон нутагт өгөх бололцоо бүрэн дүүрэн байгаа гээд л ингээд л ярьдаг. Тэгээд бас ингээд таны хувьд ямар бодолтой байгаа вэ? Энийг нэмэгдүүлэх бололцоо яг бодитоор байна уу?

Дээрээс нь яах вэ ногоон зээл гээд ингээд ирэхээр тэр пассив байшин барьдаг хэдхэн компаниудад л бариулбал өгнө. Бусдад нь өгөхгүй энэ тэр гээд нэг ийм хаалт тавигдаад ороод ирдэг юм байна лээ. Гэтэл орон нутагт тэр барилгыг хэнээс ч дутахгүй барьчих өөрөө зээл аваад, өөрөө барьчих хэмжээний маш олон хүмүүс барилгын бригадынхан хүртэл ингээд байж байгаа шүү дээ яг амьдрал дээр. Тэгэхээр тэр хүмүүсийг аваад тэр байшингаа барьчих бололцоог нь бүрдүүлж өгөөч. Нэг хэдхэн компанийг пассив гэдгээр юу гэдэг юм тэгж дэмжих биш дэмжих биш. Одоо тэр бусад хүмүүсийн бололцоог хаах биш чөлөөтэй тавиад өгвөл яадаг юм бэ гэсэн ийм нэг 2 дахь асуулт байгаад байгаа.

3 дахь нь бол одоо бидний мөнхийн асуудал болсон инфляц. Инфляц дээр Монгол банк ингээд бодлогын хүүгээс өөр одоо энэ чинь хариу арга хэмжээ авах эрх зүйн хувьд ч гэсэн хязгаарлагдмал байгаад байна шүү дээ. Гэтэл инфляц өсөөд байдаг. Тэгэхээр инфляц дээр ер нь өөр би бас асууж л байсан юм. Цаг хугацаа дуусчихлаа. Нэг минутаа эргэж авахдаа асууя.

С.Бямбацогт: Үг хэлчихэв үү. За асуултаа тэтгэврийн зээл ногоон зээлийг нэмэгдүүлэх боломжууд юу байна? Наранцогт Ерөнхийлөгч 4 дүгээр микрофон.

С.Наранцогт: Би зүгээр нөгөө өмнө нь манайхан бол Төв банкнаас авдаг тодорхой үзүүлэлтүүд зээлүүд дээр тавигддаг шаардлагыг өөрчлөх замаар бас бууруулах тухай ярьж байсан байх. Одоо энэ Төв банкан дээр зохицуулагддаг энэ өр орлогын харьцаа тэгээд тэтгэврийн зээлийг заавал байлгах нөөцөд тооцохоо больсон зэрэг энэ бүх арга хэмжээгээ султгачихсан юм. Тийм учраас энэ зээлийн өсөлт маань эрс нэмэгдсэн 80 хувиар нэмэгдсэн. Ер нь бол нөгөө Төв банк ингээд арилжааны банкны зээлийн үйл ажиллагаанд ер нь зүгээр саяын хэлдэг энэ тодорхой шалгуур үзүүлэлтийг тавьж оролцоно уу гэхээс бусдаар одоо оролцох бололцоогүй.

Ер нь авч хэрэгжүүлдэг механизмынхаа авдаг зүйлүүдээ ер нь тэтгэврийн зээл дээр авчихсан гэсэн үг. Одоо бол зүгээр банк хэрэглэгч тэр эрсдэл нөгөө энгийн зээл зээлдэгчтэй явдаг л харилцаа үүсчихсэн тэрүүгээрээ л явж байгаа. Одоо энэ дээр Төв банк нэмж оролцох бол шаардлагагүй гэсэн ийм байр суурьтай байна. Ногоон зээлийн хувьд бол би шинэ санхүүгийн тогтвортой байдлын газар дотроо ногоон санхүүжилтийн хэлтэс байгуулсан. Энэ дээр нэлээн ажиллаж байна. Тэгээд механизмын хувьд санхүүжилтийг нэмэгдүүлэх дээр би ногоон зээлийн своп дээр хөнгөлөлт гаргаж ирсэн. Энэ нь өөрөө санхүүжилтийг нэмэгдүүлэх бололцоо байгаа. Таны хэлээд байгаа нөгөө цаанаас эх үүсвэр ногоон зээл татахаар ийм ийм шаардлага яг карбон хүхрийн юу хийг хэр хэмжээгээр буулгасан юм, яаж та нар хэмжиж гаргасан юм гээд нөгөө мөшгөн хянах тогтолцоо гэж байгаа юм. Энэ нь өөрөө сул байгаа учраас энийг хөгжүүлэх, тэгээд ямар ямар үзүүлэлтийг ногоон зээл рүү ангилалд оруулах вэ гээд бичиг цаасны ажил хэрэгжүүлэх ажил Төв банк, банкнууд бусад ААН-тэйгээ ингээд цуг ажиллах энэ ажлууд дээр нэлээн ахиц дэвшил гараад явж байгаа. Яагаад гэвэл бие даасан нэгжтэй болчихсон энэ маань ажиллаж байна.

Өчигдөрхөн гэхэд бол одоо бид нар энэ арилжааны банкны удирдлагууд болоод томоохон ААН-ийн удирдлагууд яг энэ чиглэлээр ногоон зээлийг нэмэгдүүлэх энэ дээр идэвхжүүлэх ийм арга хэмжээг зохион байгуулсан. Энийг ингээд байнга хийгээд тавьсан зорилтоо 2030 онд энэ нийт зээлийн багцын 10 хувьд хүргэх ийм зорилттой одоо бол нэг 5 хувь л байгаа. Тэгэхээр ийм орон зай бол байгаа энэ рүү ингээд нэлээн ажлууд хийгдээд явж байна. Тодорхой зээлүүдийг бас ногоон зээл рүү шилжүүлэх ийм ийм ажлууд хийгдсэн байгаа.

Энэ инфляцтай ярихад бол энэ яг Төв банкны дан Төв банкны хийх ажил бол биш болчхоод байгаа. Энэ дээр Засгийн газар бүх түвшинд Их Хурал дээр ч гэсэн энэ санхүүгийн салбарын банк бус салбарын зохицуулалт хүртэл давхар орж ирнэ. Би түрүүн Ганбаатар гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Яг үндсэн асуудлыг хүмүүс яриад энэ мөнгөний нийлүүлэлт мөнгө үржүүлэх шугамыг хязгаарлах. Гэтэл өнөөдөр Монгол Улсад зөвхөн Төв банкны үнэт цаасаар түгжихээс өөр бусад дэд бүтцээ хөгжүүлж чадаагүй. Тийм учраас энэ дээр ерөөсөө бид нар Засгийн газрын бонд бид нарын сая Төв банкны хуульд өргөн барьсан тэр зүйлүүдийг хийж аваад, тодорхой энэ өмнөх зүйлүүдээ Засгийн газрын бонд руу шилжүүлээд энэ захыг хөгжүүлээд өөрөөр хэлбэл хүмүүс мөнгөтэй бол экспортын орлого нэмэгдвэл энэ орлогоо импортын болоод хэрэглээний бүтээгдэхүүн болгодог биш тодорхой энэ хөрөнгө оруулалтын хэрэгслүүд рүү байршуулж хийх бололцоо үүсгэдэг.

Дээр нь Төв банк яах вэ бодлогын хөшүүргээ хэрэглэнэ Засгийн газраас яг тодорхой бодлогуудаар яг аль хэсгүүдэд энэ санхүүжилтээ төвлөрүүлэх юм бол бид нар ирээдүйд баялаг бүтээх импортыг болоод хэрэглээг өдөөхгүй зүйл рүү шингээх

вэ л гэдэг энэ. Үндсэндээ энэ бодлого дээрээ бид нар концепцын хувьд нэгдээд бүгдээрээ нэг тийшээ харж ажиллах ёстой. Тийм учраас Төв банкнаас хамаарч байгаа төсөв мөнгөний бодлоготой холбоотой тодорхой заалтыг би өргөн...

С.Бямбацогт: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Тэр ногоон зээлтэй холбоотой асуудал дээр яг ямар шаардлагуудыг тавьчихвал тэр зээлийн эх үүсвэрээс тавьж байгаа тэр шаардлагыг хангаж байгаа вэ гэдгийг л тодорхой болгочихвол заавал нэг хэдхэн компани биш хүмүүс яг тэрэнд нь нийцүүлээд барьчихвал хамаагүй үр дүнтэй болох юм байгаа юм. Тэгэхгүй одоо яг хэдхэн компаниас авахаар нөгөө үнэтэй байшин авснаас ялгаагүй шахуу ийм дүн гарчхаад байгаа байхгүй юу 1-д.

2-т тэр инфляцтай холбоотой асуудал дээр би яг л таны наад үгийг л сонсох гээд байсан. Ганцхан ингээд мөнгөний бодлогоо хүүгээ ингээд хатуу барьчхаад байдаг өөр ямар ч арга хэрэгсэл юм байхгүй. Жишээ нь өнөөдөр ингээд Барс дээр 1600 төгрөг байгаа төмс дэлгүүрт очоод 3 мянга болчхож байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хүртэл бид ингэж бодохгүй бол төмсний үнийг 3 мянгаар нь бодоод инфляцад нөлөөлж байна гээд инфляц өндөр байна гээд бодлогын хүү өндөр болоод байдаг. Гэтэл тэр нь үр дүнд хүрч байна уу, үгүй юу гэдэг ийм асуулт байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь бүгдээрээ Их Хурал, Засгийн газар гээд...

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Идэрбат гишүүний хөндөөд байгаа асуудал дээр манай Монгол банк анхаармаар байгаа юмаа. Улаанбаатар хот, 21 аймгийн төв утаатай болчихсон. Утаагаа шийдэх гээд бид нийтийн орон сууц бариад 20 жил боллоо. Гэр хорооллын яндан ерөөсөө буурсангүй. Нөгөө л утаатай, 21 аймгийн төв нь бүр нөгөө шахмал түлш хагас кокс руу шилжээгүй учраас бүр их утаатай ийм л байгаад байгаа юм. Энийг шийдэх гээд Хэнтий аймагт, Ховд аймагт бид нар хашаандаа сайхан амьдарцгаая гээд төсөл хэрэгжүүлсэн. Гэр хороололд гал түлж байгаа, утаа гаргаж байгаа, гадаа гарч бие засаж, даарч хөрж, хөрс бохирдуулж байгаа, айлуудын дундуур цэвэр бохир усны шугам татаад өгсөн. Тэр цэвэр бохир усны шугам дээр айлууд маань өөрсдөө амины орон сууцаа бариад, хашаандаа гал түлэхгүй, утаа гаргахгүй, гадаа гарч бие засаж хөрс бохирдуулахгүй, үнс нурамтай хутгалдахгүй, халуун устай, цэвэр устай, хүйтэн устай, халаалттай, аятай амьдрах ийм боломж бүрдүүлээд өгчихсөн.

Өөрсдийнхөө хашаанд өөрсдийнхөө газар дээр тэр байшинг барихад 1м^2 нь үндсэндээ нэг сая 500 орчим мянгад босдог. Өөрийн гэсэн газаргүй, гарч бие засах, гадаа гарч тоглох тоглоомын талбайгүй нийтийн орон сууцад ороход метр квадрат нь 3 сая, 4 сая аймгуудад ийм л үнэтэй байгаа. Тийм болохоор тэр хашаандаа халуун хүйтэн, цэвэр бохир устай, дулаахан байшинг гал түлдэггүй, утаа гаргадаггүй байшинг барихад нь адилхан тэр 3 хувийн хүүтэй орон нутагт, Улаанбаатарт 6 хувийн хүүтэй гэр хороололд ийм зээлийг нь өгчих юм бол тэр иргэд чинь 3 сая, 4 сая м^2-ын үнэтэй байшинд биш метр квадрат нь сая 500-д багтах байшингаа хашаандаа өөрсдөө бариад ингээд юм уу энэ утааны асуудлыг шийдчих гээд байгаа юмаа.

Дээрээс нь цахилгааны асуудал дээр бид нар өндөр үнэтэй цахилгаан халаагуур тавих биш өөрсдөө хашаандаа нарны панел тавиад өөрөө өөрсдөө эрчим хүчээ үйлдвэрлээд дулааныхаа асуудлыг шийдээд, цахилгааны асуудлыг шийдээд, илүүдэл эрчим хүчээ төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ рүүгээ худалдаад ингээд

явах боломж бий болох гээд байгаа юм. Энэ дээр л санхүүгийн дэмжлэг орон нутагт нь тэр 3 хувийн хүүтэй ипотекийн зээлийг зөвхөн нийтийн орон сууцаас гадна инженерийн шугам сүлжээнд холбогдож байгаа цэвэр бохир усны шугамд холбогдох боломжтой айл өрхүүдэд өгдөг болчихвол Улаанбаатар хотод тэр цэвэр бохир усны шугамд холбогдох боломжтой айл өрхүүдэд нь бас 6 хувийн хүүтэй ипотекийн зээл өгдөг болчихвол өөрсдөө энэ тухтай тохитой, утаа гаргадаггүй амины орон сууцуудаа бариад хашаандаа сайхан амьдарчих гээд байгаа юм. Энэ дээр л та бүхэн бас анхааралдаа аваад нэг энэ бодлогыг нь хэрэгжүүлэхэд анхааралдхаарай гэдгийг бас хэлье ээ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. Тэмүүжин гишүүн бүлгээс үг авна.

Х.Тэмүүжин: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад АН-ын бүлэг бүлэг дээрээ бас нэг нухацтай ярих шаардлага гарч байгаа учраас завсарлага авахыг хүсэж байна. Ажлын 2 өдрийн ажлын 2 хоногоор завсарлага авах хүсэлт гаргаж байна аа.

С.Бямбацогт: Уул нь одоо бас асуудлуудаа явуулаад л баймаар байдаг. Чуулган завсарлах гээд байгааг та бүхэн ойлгож байгаа байх. Тийм болохоор өнөөдрийн ажлын цаг дуустал завсарлага өглөө. Маргааш өглөө санал хураалтыг явуулна. 10 цагаас. Тэгээд та бүхэн маргааш өглөө гэхэд бас дотроо юмаа ярилцаадхаарай. АН-ын бүлэгт өнөөдрийг дуустал завсарлага өглөө.

15.52 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Гурав.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Б.Түвшин нарын гишүүд өргөн мэдүүлсэн,* ***эцсийн хэлэлцүүлэг****/*

С.Бямбацогт: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Хэрлэн танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Б.Хэрлэн: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн нэгтгэсэн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Монгол Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 8 гишүүнээс 2026 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Монгол

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин нарын 41 гишүүнээс 2025 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг Улсын Их Хурал 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг 5 хүртэлх ажилтантай ажил олгогчийг дэмжиж, ажил олгогчийг төлөх тэтгэвэр тэтгэмжийн даатгалын шимтгэлээс тодорхой хугацаанд чөлөөлөх зохицуулалтын хэрэгжилтийн үр дагавар, үүсэж болох эрсдэлээс хэрхэн сэргийлэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг баримтлан зарчмын зөрүүтэй 4 саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төслүүдтэй холбогдох зүйл, хэсэг заалтад нэмж тусган, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаарыг нийцүүлэн өөрчилж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төслийг та бүхэнд тараасан болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа. Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Ганзориг.

Б.Пүрэвдорж: Баярлалаа. Монголын ард түмнийхээ болон гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсгийг танилцуулъя. Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Лхагвасүрэнгийн Мөнхзул Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга, Басангийн Батжаргал НДЕГ-ын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын дарга, Энхбаатарын Тамир МҮЭХ-ны ерөнхийлөгч, Баасангийн Алтанхуяг МҮЭХ-ны орон тооны бус дэд ерөнхийлөгч, Чимэдцэрэнгийн Нанжидсамбуу Монголын ажил олгогч эздийн холбооны дэд ерөнхийлөгч, Энхтайваны Энхжаргал Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны Хөдөлмөрийн харилцаа, эрх зүй, нийгмийн бодлогын газрын дарга, Чимэдгочоогийн Өнөржаргал СЭЗИС-ийн багш, судлаач, Эрдэнэбатын Цэрэнбат Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Бат-Эрдэнийн Баянжаргал Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Гомбожавын Анхбаяр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Дамдинсүрэнгийн Отгонтуяа Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Ганболдын Мишээл Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн, Бямбаагийн Мөнхбаяр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал хуримтлалын сангийн бодлогын газрын ахлах шинжээч, Маамын Бямбадулам НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Загасын Пунцагцэрэн НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, Алтансүхийн Уртнасан НДЕГ-ын Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн.

Ажлын хэсгийнхэн Их Хурлын гишүүдэд үнэн зөв мэдээлэл өгч мөн түүнчлэн буруу мэдээлэл өгөх юм бол хуулийн хариуцлагатай гэдгийг анхааруулъя.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Одонгийн Цогтгэрэл гишүүн алга байна, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн алга байна, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн алга байна, Ганзоригийн Лувсанжамц гишүүн алга байна, Эрдэнэболд уу? Эрдэнэболд шүү дээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууна.

Б.Мөнхсоёл: Өчигдөр асуулт асууж, үг хэлэх байсан тэгээд санамсаргүй өнгөрөөсөн байна лээ. Тэгээд өнөөдөр зүгээр асуулт биш бараг үг хэлчихье дээ. Ер нь бол Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт, нэмэлт, өөрчлөлт ороод энэ нийгмийн тэтгэврийн сангийн шинэчлэлийг хийж байгаа энэ үйл явц эхэлж байгаад бол баяртай байгаа, дэмжиж байгаа. Зүгээр сануулж бас цаашдаа анхаарах ёстой зарчмын зүйлүүдийг хэлсэн нь зөв байх аа гэж бодож байгаа. Манай Аубакир сайд өөрөө байна.

Тэгэхээр хамгийн гол нь одоо төлж байгаа ажилтан ажил олгогчийн НДШ-ийн хувь хэмжээ чинь хэвээрээ байгаа. Нөгөө талдаа ажил олгогчийн нийт цалингийн сангийн 5 хувийг татвараас чөлөөлнө гэж нэг жижиг мотивацлах зүйл. Тэгэхдээ энэ

хэмжээг яагаад 5 гэж гаргасан. 2 дугаарт ажилтан талдаа бол 1.2 сая төгрөгийг гээд ийм мотивацлах энэ тал бол бас хангалттай ороогүй юм уу даа гэсэн ийм цаашдаа анхаарах зүйл байгаа юм. Яг нөгөө жинхэнэ утгаараа тэтгэврийн сан чинь урт удаан хугацааны хөрөнгө оруулалтын сан болоход анхаарах ёстой зүйлүүд байна аа гэж. Энэ зүйлийг бас хэлмээр байгаа юм.

Ер нь бол хувийн тэтгэврийн сан үүсэхэд ажилтан талд мотивац өдөөгдөх тэр хүчин зүйл чухал. Өөрөөр хэлэх юм бол тэртээ тэргүй улсад 11.5 хувийн шимтгэл төлж байгаа бол юугаараа илүү гаргаж одоо хувийн тэтгэврийн санд мөнгө оруулах вэ, хуримтлуулах вэ? Эсвэл одоо боломжтой улсууд нь арилжааны банк, үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулдаг хэвээрээ байна аа. Тэрэнтэй харьцуулахад илүү одоо өгөөжтэй, илүү боломжийг нээсэн байх ёстой. Мэдээж нэгэнт одоо хувийн тэтгэврийн сангууд үүсчих юм бол хувийн секторт урт хугацааны хөрөнгө оруулалтын боломжуудыг нээх маш ийм таатай зүйл болно гэдгийг бол тэр утгаараа энэ реформын эхлэлийг дэмжиж байгаа юмаа.

Хоёрдугаарт нь энэ баталгаат тэтгэврийн одоо үе байна шүү дээ 3 шатлалт гээд анхны шатлалт нь баталгаат гээд 100-300 мянган төгрөгийг орлого доогуур байгаа иргэддээ олгоно оо гээд. Тэгээд тэр асуудлыг бас гүйцэж судлах ёстой гэж үзэж байгаа. Үндсэн нийгмийн даатгалын сангаасаа авч байгаа тэр дүнтэй уялдуулж дүйцүүлж сайн томьёолж тооцохгүй бол бас бодит амьдрал дээр хийдэл гарах вий гэсэн ийм анхааруулга байгаа юмаа.

Гуравдугаарт нь болохоор тэр босго тавимаар юм шиг санагдсан. Одоо татварыг чөлөөлөх хэсэг дээр ямар одоо хэд хүртэл төгрөгийн орлоготой дээр ямар хэмжээний татварын чөлөөлөлт байх вэ? Илүү өндөр орлоготой иргэд дээр арай бага хөнгөлөлт байх ч юм уу ийм босго зааг хэрэгтэй юм шиг бас тооцоолол арай дутмаг юм шиг санагдсан шүү.

Цаашдаа илүү боловсронгуй хөгжсөн улсуудын түвшинд аваачихад явцын дунд сайжруулах хэрэгтэй гэдэг энэ тал дээр бас саналаа хэлмээр байгаа юм. Тэгээд Хүн намын мөрийн хөтөлбөрт орсон ийм олон реформын олон салбаруудад хийх ёстой нэг реформ шинэтгэлийн ажил ийнхүү эхэлж байгаад дэмжиж үг хэлж байгаа. Тэгээд анхаарах зүйлийг бол сануулж зориуд протоколд оруулж байгаа юмаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Ганзоригийн Лувсанжамц гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

С.Эрдэнэбат: Нийгмийн даатгалын одоогийн хуримтлалын нэрийн дансанд үлдэж байгаа 2 хувийг 1 хувь руу яаж шилжүүлэх вэ гэдэг энэ тал дээр нэг тодруулга мэдээлэл өгөөч. Бас нэлээн олон хүмүүс асуугаад байгаа учраас Нийгмийн даатгалын газар. 2023 оноос авхуулаад нэрийн дансанд нийт шимтгэлийн 2 хувийг үлдээсэн. Одоо тэнд яг ер нь хэдэн төгрөг яг албан ёсоор мөнгөжчихсөн байгаа вэ? Хэдийг нь одоо шинээр хуулиар 1 хувийг өгөх юм бол Засгийн газар. Одоо 50 хувийг урамшуулал олгоё гэж байгаа шүү дээ тиймээ. Энэ тал дээр яг яах вэ гэдгээр нэг тодорхой мэдээлэл өгөөч ээ.

Ажил олгогчийн хязгаарыг тавьснаас хамааруулаад нийтдээ яах вэ нэг удаа хөнгөлөлт эдлэх 100 мянган хүн байна гэсэн. Одоо 8 саяас дээш хэмжээний цалин

нэг удаа авсан 100 мянган ажилтан байна гэсэн. За энэний одоо нөгөө талынх нь үр дагавар буюу хэчнээн компани ААНБ-ын хэдэн төгрөг яг хөнгөлөгдөхөөр байгаа вэ гэдэг надад яах вэ өнөөдөр асуулт дээр бүрэн хариулж бичгээр яг албан ёсоор өгөөч ээ. Энэ цоорхойг хаанаас яг яаж нөхөх вэ гэдэг бүүр компаниудынх нь нэрээр байвал, салбараар нь байвал сайн байна гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт нь хэвийн бус нөхцөлийн асуудал байж байгаа. Ямар ч байсан бол энэ хэвийн бус нөхцөлийг энэ удаадаа орхисон. Тэгэхдээ цаашид дахин дахин энэ асуудлыг ажлын байрных нь нөхцөлийг сайжруулах асуудалтай зэрэгцүүлж орж ирэхгүйгээр ингээд хөндөөд байж болохгүй ээ. Нийгмийн даатгалын хууль ярих болгонд ингээд шууд орж ирээд байгаа ийм асуудал байж байгаа. Тийм учраас цаашлаад магадгүй хүнд хортой нөхцөлд ажиллуулаад уул уурхай гэдэг юм уу, зам тээвэр гэдэг юм уу, эрчим хүч гэдэг салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хүмүүсийг нь одоо насыг нь нэмнэ гэдэг гэхээсээ илүүтэйгээр магадгүй шаардлагатай бол тэр салбарт нь шимтгэлийг нь тодорхой хэмжээгээр бүүр нэмэгдүүлж байгаад тэр хүмүүсийг хохироохгүй байх гэдэг талынх нь хувилбаруудыг бодох хэрэгтэй шүү. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуультай холбоотойгоор бас энэ асуудал дараа яригдах учраас Үйлдвэрчний эвлэлийн санал тэрийг харж байгаад энэ удаадаа бол хойш нь тавьсан. Гэхдээ энэ асуудлыг нэг тийм гэнэт гэнэт оруулж ирдэг байдлаар биш цаашдаа энийг бол би анхааараарай гэдгийг хэлмээр байна.

Энэ хуулиас манай ялангуяа 80-аад, 79 оны 1 сарын 1-нээс хойш төрсөн 80-аад оны хүмүүс байсан. Одоо үндсэндээ 2 жилийн дараа 79 оны 1 сарын 1-нд төрсөн хүн бол 4 хүүхэдтэй эмэгтэй хүн тэтгэвэрт гарахаар байсан. Тэтгэвэр нь бол 40 хувь бууруулах, дунджаар бол тооцоолол байсан. Тэгээд энийг бол одоо цалинд суурилсан аргаар бодохоор өөрчилж байгаа. Энэ тал дээр миний хувьд санаа зовж байсан ийм зүйл байсан. Одоо ингээд ямар ч байсан шийдэгдсэнд таатай байгаа. Гэхдээ цаашдаа хагас хуримтлалын гэдэг энэ хувийн тэтгэврийнхээ юмыг цааш нь явуулахад Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө боломж бололцоотой байх юм бол одоо төлж байгаа 17 хувиасаа тодорхой хувийг тэр хүнд нь өвлүүлэх гэдэг энэ асуудал чухал шүү.

Мөн нөгөө талаар тэтгэврээ огт авч чадахгүйгээр нас барж байгаа хүмүүс байгаа. Ялангуяа манай эрчүүд байдаг. Энэ хүмүүсийг одоо хохироохгүй байх гэдэг энэ асуудлыг дараагийн ээлжийн тэтгэврийн реформ болоод үлдэж байгаа шүү гэдгийг би онцгойлж хэлмээр байгаа юм. Тэгэхээр тэтгэврээ авч чадахгүйгээр яг нас барж байгаа хэчнээн хүн ер нь бол тухайлбал энэ жилд байдлаар байгаа вэ гэдэг тал дээр тоо байвал та бүгд маань хэлээд өгөөч гэдгийг хэлмээр байна.

Оюутан залуучуудыг дэмжсэн манай Ганхүлэг тэр гишүүд яриад насыг жоохон нэмсэн анагаах эд нар гээд. Энэ олон гэрээ мөн нэг л гэрээнээс авна гэдгээр болсон. Энэ олон боломжуудыг яах вэ нэг талаараа залууст их боломж олгож байгаа таатай зүйл. Хөлсөөр ажиллах бүх гэрээ хөлсөөр ажиллах болчихвол энийг хэт их буруугаар ашиглах юм бол буцаагаад л байранд нь тавихаас байдал руу орох ёстой. Тийм учраас манай ажил олгогч нар маань энэ тал дээрээ нийгмийн даатгалаас зугтаахгүй байх гэдэг талаар...

Б.Пүрэвдорж: Ажлын хэсгийн ахлагч Булгантуяа хариулъя.

Х.Булгантуяа: 2023 онд нийгмийн даатгалын бид нар багц хуулийг баталж нэлээдгүй өөрчлөлт хийсэн. Тухайн үеийн энэ өөрчлөлтүүдээр нэлээн ахиц дэвшил

гарсны нэг бол жишээлбэл жил болгон инфляцтай уялдуулж бид нар тэтгэврийг нэмэгдүүлдэг болсон. Өмнө нь бол зарим жилүүдэд алгасдаг, заримдаа ахмадуудын их бухимддаг байсан нь яг сонгууль дөхүүлж байгаад л нэмдэг зарчим нь их тодорхойгүй. Яаж нэмэгдээд байгаа зарчим нь ч тодорхойгүй байсан энэ тэр гэсэн үүнийг өөрчилсөн. Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн мөнгийг яаж байршуулах вэ гээд банканд дахиж тавиад алдчихгүй байх эрх зүйн орчныг чангатгасан.

Дээрээс нь нэмээд энэ үлдэгдэлтэй холбоотой санхүүгийн менежментийг хийх тусгай зөвлөл байгуулах гэх мэтчилэн нэлээдгүй өөрчлөлтүүдийг хийсэн. Энүүн дээр орсон нэг том өөрчлөлт бол 2023 онд ингээд батлагдаад, 2024 оны 1 сарын 1-нээс хэрэгжиж эхлэх байсан нийгмийн даатгалын шимтгэлийн тэтгэврийн шимтгэлийн 17 хувиас жил болгон 2 хувийг мөнгөжүүлнэ. Одоогийн манай шимтгэл бол энэ талаас нь шимтгэл төлөгчид 1.2 сая хүнээс аваад л шууд нөгөө гараараа бид нар 500 мянган тэтгэвэр авагчдад тэтгэвэр болгож өгдөг. Гэтэл энэ нь бид нар 2 хувийг нь гар хүрэхгүйгээр уг нь хуримтлуулаад ингээд эдийн засгийн боломж бололцоогоороо ахиад цааш нь бүүр нэмэгдүүлээд ингэж явъя гэж байсан. Харамсалтай нь энийг бол тууштай хэрэгжүүлж чадаагүй.

Одоо нийтдээ бид нар тооцоолол хийж үзэхэд 2024 оны 1 сарын 1-ээс ингээд бүрэн мөнгөжүүлээд явахад 2024 онд нийтдээ 500 гаруй тэрбум төгрөг мөнгөжхөөр байсан. Ингээд 2025 он, 2026 он гээд дундаж цалин хөлс нэмэгдэхээр 2 хувь нь бас нэлээдгүй мөнгөжөөд явах байсан. Одоо нэг 300 гаруй тэрбум төгрөг тийм ээ Аубакир сайд. Байгаа, мөнгөжсөн байна гэсэн үг. Тэгэхээр Улсын Их Хурлаар батлагдсан хуулийг Засгийн газар ийнхүү сонголттой хэрэгжүүлмээргүй байна аа. Хэрвээ нэгэнт л ард түмэндээ амлаад Улсын Их Хурлаар өдөржин шөнөжин хэлэлцээд та бүхэн нэгэнт мөнгөжүүлнэ гэсэн бол мөнгөжүүлээрэй. Одоо бол 1.5 хувь болох гэж байна. Нэг хувийг нь нийгмийн даатгалын тэтгэврийн шимтгэл төлсөн бид нарын 1 хувь, нөгөөдөх нь болохоороо 0.5 хувийг улсын төсвөөс нийтдээ 1.5 хувийг жил болгон мөнгөжүүлнэ гэж. Үүнийгээ тууштай хийгээрэй.

Ажил олгогчоос олгох, төлөх ёстой тэтгэврийн шимтгэлийн 10 хувь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс 10 хувиас хэтрүүлэхгүйгээр төлөхөөр болж байна. Үүнтэй холбоотой бас орлого нэлээдгүй буурна. Тэгэхээр өөрөөр хэлбэл 8 саяас дээш цалинтай хүмүүст ажил олгож байгаа ажил олгогчдын хувьд төлж байгаа шимтгэлийн хэмжээ тэтгэврийн шимтгэлд төлж байгаа хэмжээ нь буурна аа гэсэн үг. Үүнтэй холбоотой бас орлого нэг 300, 400 орчим тэрбум төгрөгөөр тиймээ буурахаар байсан. Энэ бол бас манай нийгмийн даатгалын сан дээр орлого нөгөө талдаа буурна. Гэхдээ нөгөө талдаа Ерөнхий сайдын чөлөөлье гэж ажил олгогчдыг дэмжиж байгаа том бодлогын энэ бол нэг хэсэг нь юмаа. Хүнд нөхцөлийг бол бид нар бас ярих ёстой.

Б.Пүрэвдорж: Нэмж нэг минут хариулъя.

Х.Булгантуяа: Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенцоор бид ер нь хүнд нөхцөлийг арилгах үүргийг Монгол Улс авсан байж байгаа юм. Бүүр хортой нөхцөл, газрын гүн гэх мэтчилэн энийг бол бүрэн арилгаж чадахгүй дэлхий даяараа ийм байгаа. 2008 онд тухайн үед ярьж байсан бид нар бас хойшлуулъя гээд л хойшлуулж байсан. 2017 онд ОУВС-ийн хөтөлбөрт орж байхад цаг хугацаа нь биш байна аа гээд хойшлуулж байсан. 2023 онд бас хойшлуулж байсан. Одоо бол Үйлдвэрчний эвлэл ажил олгогчидтой юу гэж тохирч байна гэхээр 1 дүгээрт ер нь

хөдөлмөрийн хүнд нөхцөлийг бууруулах хөтөлбөртэй болъё. Үүн дээрээ бас төсөв санхүү гаргая, ажил олгогчдыг үүн дээр шахъя. Ингэж байж хүнд нөхцөлийг бууруулъя.

Ер нь хүмүүсийг хүнд нөхцөлд 20, 30 жил ч байдаг юм уу ажиллуулж байгаад бүүр хүнд өвчтэй болгоод тэтгэвэрт та гар аа, арай тэгэхдээ үүнийхээ үүнд чинь одоо бараг шагнал болгож гэж байгаа юм шиг нэг 5 жилийн өмнө тэтгэвэрт гарах боломж олгоё гэдэг бол яг үнэнийг хэлэхэд энэ бол төрийн маш харгис бодлого. Тийм учраас Хөдөлмөрийн хуульд ХАБ-ын тухай хуульд тодорхой өөрчлөлтүүдийг хийгээд ХАБ...

Б.Пүрэвдорж: Аубакир сайд нэмж нэг минутаар хариулъя.

Т.Аубакир: Бидний хувьд энэ нэмэлт өөрчлөлтөөрөө нэлээн өргөн хүрээнд яг нийгмийн даатгалын энэ харилцаанд оролцож байгаа субъектүүдийн эрх ашиг яг нийцүүлж нэлээн өөрчлөлтүүд хийсэн л дээ. Тэгээд энэ хууль дээр бид нар хүнд хортой биш ээ, хортой, газар доор, халуун нөхцөлийг бол хөндөөгүй, хүнд нөхцөлийг сая Булгантуяа гишүүн хэллээ. Бид нар олон улсын гэрээ конвенцоороо хүнд нөхцөлийг багасгах ийм үүргүүд хүлээж байдаг. Маш олон жил энэ хүнд нөхцөлийг сайжруулах талаар хөдөлмөрийн харилцаанд оролцож байгаа талууд ажиллаж байгаа. Сая бас хүнд нөхцөлийг хөндөж орж ирсэн. Талуудын зөвшилцсөнөөр энэ удаа хөндөхгүйгээр орхиж явна. Нөгөө талдаа ажил олгогч маань тухайн иргэнийг хүнд нөхцөлд олон жил дараалан ажиллуулахгүй байх үүргийг бас давхар хүлээх ёстой. Нөгөө хүн нь одоо хүнд нөхцөлд ажиллуулаад байдаг, тэтгэвэрт гарах нас нь дөхчихдөг үндсэндээ тэгээд группт орох шахуу болоод л тултал нь ажиллуулаад гаргадаг. Гэтэл энэ чинь өөрөө бас нөгөө ажил олгогч маань хөдөлмөрийнхөө тэр цаг нар янз бүрийн юмандаа зохицуулалтуудаа хий...

Б.Пүрэвдорж: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн нэмж тодруулъя.

С.Эрдэнэбат: Нөгөө 2 хувийг 1 хувь руу яаж шилжүүлэх вэ гээд би тодорхой тэрэн дээр маш олон хүн асуугаад байгаа учраас яг тодорхой манай хэн нэг хариулаад өгөөч. Одоо нэрийнх нь дансанд байгаа 2 хувьтай бүртгэгдээд байгаа хүмүүсийг шинээр буй болгож байгаа 1 хувь руу шилжүүлэх боломж бололцоо нь яг яаж гарч ирэх вэ гэдэг ийм асуудал байж байгаа.

Дараагийнх нь нэг асуудал нь энэ 5-аас ер нь бол яах вэ насыг дунджаар нэг 3 сараар одоо 29, 30-аад оноос ингээд нэмэхээр байгаа. Дундаж наслалт өсөж байгаатай холбоотойгоор. Гэхдээ энэ шударгаар төлж байгаа хүмүүстээ хохиролгүй байх, хүндэтгэн үзэх шалтгаанаар 1 сар, 2 сар энэ тэр гээд л 3 сар, 6 сар хүртэл ингээд л ажилтай ажилгүй болдог. Энэ эрсдэлүүдийг нь бас уян хатан тооцож өгөх гэдэг юман дээр анхаараарай. Тэгэхгүй бол яг шударга төлж байгаа хүмүүс маань одоо энийг сүүлийнхээ 5 жилийг өндөр тогтоолгоод хуулийн цоорхой ашиглаад, өндөр тогтоолгоод байгаа хүмүүсээс болоод энэ асуудал хөндөгдсөн учраас та бүгд маань энэ дагах журам, томьёо энэ дагах хуулиуд дээрээ бас боловсронгуй болгож оруулж ирье гэдгийг би бол...

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Хэн хариулах юм? Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон нэр, албан тушаалаа хэлээд хариулаарай.

Б.Батжаргал: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. НДЕГ Б.Батжаргал. 1 хувь ба 0.5 гэсэн хувилбар дээр өмнө нь хуримтлуулсан байсан тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө дээр шилжилтийн хугацаа өгч байгаа. Тэгээд энэ сайн дурын үндсэн дээр хэрэгжих хөтөлбөр учраас хэрвээ хүсэлтээ гаргасан даатгуулагч байвал одоо хуримтлагдсан байгаа мөнгөний дүнгий нь мөнгөн хөрөнгийнх нь эхний үлдэгдэл болгож зоогоод тэр хүний бүртгэл дээр нь цаашаа аваад явна аа гэсэн ийм байдлаар Дагаж мөрдөх журмын тухай хууль дээр зохицуулалтыг нь оруулчихсан байгаа тийм. За баярлалаа.

Б.Пүрэвдорж: Одоо Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн өөрчлөлтөөр ААН-үүдэд бас эерэг нөлөөтэй нэлээн хэдэн заалтууд орсон байгааг онцолж хэлмээр байна. Тэгээд 1 дүгээрт нь болохоор энэ даатгуулагчийн нийгмийн даатгал төлөх цалин орлогын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин үржүүлснээр ингээд хязгаарладаггүй байсан. Гэхдээ өндөр ажил олгогчоос ажилтныхаа төлж байгаа өмнөөс төлж байгаа энэ шимтгэл дээр болохоор ямар нэгэн хязгаар байдаггүй байсан. Тэгэхээр энийг 2028 оноос эхлээд аажим аажмаар 12, 11, 10 болгож ингэж өөрчилж оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ бол ажил олгогчдын хувьд бол өндөр цалин төлөх энэ сэдлүүдийг бий болгож байгаа. Энэ хэмжээгээр татварын хэмжээнүүд нь буурч байгаа учраас ажил олгогчийг энийг сайн анхаарч ашиглаасай гэж бодож байна.

Өөр нэг заалт болохоор энэ хөдөлмөрийн зах зээлийг тэлэх үүднээс оюутан залуучуудтай холбоотой 15-22 насны энэ залуучуудыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс бусад нийгмийн даатгалаас чөлөөлөгдөж тэгээд энэ ажил олгогч нь энэ шимтгэлээс чөлөөлөхөөр иймэрхүү зохицуулалтууд бас орж ирж байгаа. Энэ болохоор бас мөн 2028 оноос хэрэгжихээр ийм заалт орж ирсэн байгаа. Тэгэхээр энэ бол хөдөлмөрийн зах зээлийг тэлж байгаа оюутан залуучуудыг бас энэ зах зээл дээр оруулж ирэх энэ бололцоо боломжууд нь нээгдэж байгаа. Тэгээд энийг бас ашиглаарай гэж хэлмээр байна.

Дээр нь тэтгэвэрт гарсан ялангуяа одоо энэ залуучуудтай энэ тэтгэврийн насныхан цуг ажиллахад энэ хөдөлмөрийн бүтээмжүүд их сайнаар нөлөөлдөг олон улсын судалгаанууд байгаа. Тэгэхээр энэ хөдөлмөр тэтгэврийн насныхныг хөдөлмөрийн зах зээл дээр татах энэ бололцоо боломжуудыг эдийн засгийн хөшүүргээр дэмжиж өгч байгаа. Тэтгэврийн даатгалын шимтгэлээс нь чөлөөлөх ийм зүйл заалтуудыг энэ хуулийн төслөөр оруулж ирсэн байна.

Дээр нь энэ шинээр жижиг бизнесүүд дээр 5 хүртэлх ажилтантантай компаниудын хувьд бизнес эрхлэгчдийн хувьд бол 3 хүртэлх ажилтнаа НДШ-ийг нь төлөхгүй 3 жилийн хугацаанд төлөхгүй байхаар ийм бас бололцоо боломжуудыг олгож байгаа. Тэгэхдээ ажилтны эрхийг нь хөндөхгүй энийг нийгмийн даатгалыг нь төлснөөр ингээд тооцож явахаар гэх мэтчилэнгээр гээд ийм эерэг заалтууд ажил олгогчдын зүгээс нэлээн орсон. Тэгээд энийг гэхдээ яг одоо энэ хэлэлцүүлгийн явцад бол ний нуугүй хэлэхэд ажил олгогчдын төлөөлөл маань маш хангалтгүй оролцлоо. Засгийн газар өөрсдөө бараг санаачилж энэ саналуудыг ажил олгогчдын өмнөөс бараг ингэж санал санаачилга гаргаж энэ өөрчлөлтүүдийг оруулж ирж байна. Гэтэл энэ ажлын хэсэг дээр Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо л байна. Тэгээд бусад энэ бид нарын төлөөлдөг гэж ярьдаг МҮХАҮТ бусад газрууд энэ дээр маш хангалтгүй оролцлоо. Нэг санал нэг компаниудаас өгсөн саналуудыг дамжуулах төдийд л нэг уулзалт хийсэн байх. Тэрнээс өөрөөр ерөөсөө оролцсонгүй.

Тэгэхээр энэ цаашдаа энэ өөрөө нийгмийн даатгалын энэ харилцаа чинь бол ажил олгогч, үйлдвэрчний эвлэл, ажилтан, үйлдвэрчний эвлэл тэгээд Засгийн газар гэсэн ийм хамтын шийдэл уулзвар, нийтлэг эрх ашгуудын уулзвар байдаг. Тэгээд энэ дээр ийм нарийн юм тохирч байхад ажил олгогчид маань бас яг энийгээ цаашид анхаарахгүй бол ийм хайнга тэгээд дараа нь юм болоод өнгөрчихсөн хойно нь энэ ч болохгүй, тэр нь ч болохгүй, энэ нь ч өндөр байна гээд ийм байдалд бас ормооргүй байна аа. Мэдээж энэ яаралтай горимоор явсан байгаа. Тэгэхдээ одоо Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо маань харин энэ дотроо оролцоод дуу хоолойгоо өргөөд явж байгаа.

Тэгэхээр энэ ААН-үүдийн энэ төлөөлөх чадварыг сайжруулах, нийтлэг эрх ашгийн төлөө ингээд ажилладаг байхгүй бол энэ чиглэлээр уул нь танхимын хуулийг санаачилсан боловч одоогийн танхимын удирдлагууд нь хэдэн зөвлөхүүдтэй нийлж байгаад энэ танхимын хуулийг унагасан. Тэгэхээр бизнесийн энэ салбарыг төлөөлөх энэ чадварыг бас сайжруулмаар байна. Ийм хуулиуд дээр саналаа идэвхтэй өгдөг баймаар байна аа гэж хэлмээр байна.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн асуулт асууж. үг хэлнэ.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ Байнгын хороон дээр энэ чухал хуулийн төсөл орж ирж бас нэлээн яригдсан. Түрүүнд энэ Энхтүвшин гишүүн болоод бусад гишүүд энэ хуулийн ажил олгогч талдаа, ажилтан талдаа өөрөөр хэлбэл НДШ-ийг хамтран төлж байгаа энэ хөдөлмөрийн харилцаанд оруулж байгаа 2 талын аль алинд нь хэрэгтэй ийм талуудыг дурдлаа. Ялангуяа Хүн намын мөрийн хөтөлбөрт байгаа энэ залуу үеийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өөрөөр хэлбэл энэ 15-22, 23 насны залуучууд НДШ-ээс яг үндсэн хөдөлмөрийн гэрээ байгуултлаа чөлөөлөгддөг байх сонголтыг бий болгосон явдлыг бол бид бас нэлээн дэвшилттэй гэж харж байгаа. Нөгөө талдаа бол олон тулгуурт тэтгэврийн тогтолцоог бол дэмжих, тэтгэврийн мөнгөн хуримтлалын яг бодитойгоор бий болгохыг нэг хувь, тэгээд тэрэн дээр нэмэх нь яг энэ одоогийн товчилсноор энэ хөдөлмөрийн нэрээр нь хэлэхэд Хөдөлмөрийн яамнаас жил болгон 50 тэр нийлээд ерөөсөө энэ хуримталсан мөнгөн дээр нь 50 хувийг нэмэх, өөрөөр хэлбэл 1.5 хувийн ийм хуримтлал бий болгож байгаа эдгээр явдал бол сайн гэж харж байгаа юм.

Зүгээр тодруулж асуух юм нь яг байнгын хороон дээр асуудлыг хэлэлцэж байхад Засгийн газраас оруулж ирсэн энэ хуулийн төсөл дээр юу яригдсан бэ гэхээрээ шүүгчдийн тэтгэврийн асуудал дээр Засгийн газрыг саналаа буцаан татах гэсэн ийм санал орж ирж тэр нь бол дэмжигдсэн байгаа. Тэгэхээр энэ шүүгчдийн энэ тэтгэвэр гэдэг нь ямар учиртай юм. Яагаад энэ нийгмийн даатгалынхаа ерөнхий хуультай холбоотойгоор энэ тэтгэвэртэй холбоотой нийгмийн даатгалынх нь харилцаа нь тэнд тооцдог тооцоолол нь өөр байдаг юм. Үүнийг бас нэг яг энэ микрофоныг ашиглаад асуучихъя гэж бодлоо. Яагаад ийм байгаа юм. Энэ ямар учиртай юм. Энийг бас тодруулж энэ ажлын хэсгийн ахлагчийн зүгээс мөн одоо энэ асуудлаа мэдэж байгаа экспертүүд мэргэжилтнүүд нь хариулбал сайн байна.

Хоёрдугаарт энэ Засгийн газрын хувьд 3 их наяд төгрөгийн шинэ эх үүсвэр хэрэгтэй ийм л юм орж ирж байгаа шүү дээ. Янз янзын харилцаанд Засгийн газрын зүгээс төсвөөс одоо мөнгө нийлүүлэх ийм шаардлагатай болж байгаа. Энэ мөнгө санхүүгийнхээ эх үүсвэрийг хэрхэн тооцож цаашдаа энэ 2027 оны төсвөөс эхлээд

энийгээ тусгаж чадах вэ гэдгийг асууя. Тэгэхгүй бол одоо энэ хууль чинь зүгээр хоосон цаас болно.

Гуравдугаарт нь энэ цэргийн тэтгэврийн асуудал энэ дээр ямар дэвшил гарав аа. Тэрийг бас энэ байнгын хороон дээр ярилцах үеэр би сайн мэдээлэл авч чадсангүй. Ийм учраас асууя. Одоо улс орноо батлан хамгаалах ийм үйлсэд зүтгэсэн ийм олон цэргийн албан хаагчид бий. Энэ хүмүүсийн тэтгэврийн асуудал энд хэрхэн тусаж ямар сайжруулалт энд бий болсон бэ гэсэн ийм 3 асуултыг асууя аа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Аубакир сайд хариулъя.

Т.Аубакир: Хууль дээр яах вэ нэг мөр ойлголттой болохын тулд шүүх, прокурорын нийгмийн даатгал, тэтгэврийн асуудлыг тусгаж орж ирсэн. Нөгөө талдаа одоо шүүх засаглал бас арай өөр зохицуулалтаар явдаг. Ямар асуудал үүсээд байсан юм гэхээр яг шүүх прокурорт ажиллаж байгаа хүмүүс маань тэтгэврээ тогтоолгох гээд нийгмийн даатгалын байцаагч дээр очихоор 2 хууль болчхоод байгаа юм. Шүүхийн тухай хууль мөн манай нийгмийн даатгалын санд шимтгэл төлөгчийн нөгөө шимтгэл төлсөн ажилласан жилтэй нь уялдаатай холбоотой. Ингээд олон кэйсүүд гарч байсан. Шүүх прокурорт ажиллаж байсан хүмүүс маань тэтгэврээ яг аль хуулиа барьж одоо тэтгэврээ тогтоолгох нь ойлгомжгүй байдалтай байсан. Тэгээд бид нар энэ удаа хууль дээрээсээ татаад дараа нь ер нь энэ 2 салбарын тэтгэврийн асуудлыг нэг мөр ойлгогдох аль нэг хууль дээр тусгаж явах шаардлагатай гэж үзэж байгаа. Нөгөө талдаа бас шүүх засаглал гэдэг утгаараа бид нар арай өөр зохицуулалттай байх ёстой.

2 дахь таны асуулт цэргийн тэтгэврийн асуудал яг манай концепц дээр өмнөх өвлөгдөх зохицуулалт бол цэргийнхэнд байгаагүй. Яг одоо энэ шинэ зохицуулалтаар бол цэргийн албан хаагчид маань саяын өвлөх зохицуулалтыг эдлээд явна. Мөн цэргийнхэнд бид нар суурь тэтгэвэртэй болгож оруулж ирж байгаа гэснээрээ энэ нэмэлт, өөрчлөлт маань онцлогтой байгаа юм. Өмнөх 2024 оны хууль байх аа тиймээ нөгөө өвлөдөг зохицуулалт маань байдаггүй байсан шүү дээ цэргийн тэтгэвэр албан хаагчид маань аль нэг нь өөд болсон тохиолдолд өвлөгддөггүй байсныг энэ шинэ нэмэлт өөрчлөлтөөрөө өвлөгддөг болгож оруулж ирж байгаа юм.

Б.Пүрэвдорж: 3 дахь асуултад ажлын хэсэг 4 дүгээр микрофон хэн хариулах вэ? За төсөвт нөлөөлөх нөлөөлөл.

Б.Батжаргал: Наранбаяр гишүүний асуултад хариулъя. НДЕГ Батжаргал. Цэргийн тэтгэврийн хувьд бол суурь тэтгэврийг яг адилхан олгохоор тусгаж өгсөн байж байгаа. Нийтдээ энэ суурь тэтгэврийн жинхэнэ тогтолцоо бүрдэж байгаатай холбоотой төсөв нь бол нийтдээ 1.2 их наяд төгрөг байгаа. Бусад зардлын нөлөөллүүд ороод ойролцоогоор 2.4 их наяд төгрөгийн нөлөөлөлтэй байгаа. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Нэмж тодруулъя Наранбаяр гишүүн.

П.Наранбаяр: Тэгэхээр энэ 3 их наядаасаа задлаад бас тайлбарлаад өгөөрэй. 2 дугаарт нь яах вэ зүгээр энэ яг шүүгч, прокурорын яг энэ тэтгэврийн асуудал. Уг нь энэ нийгмийн даатгалынхаа ерөнхий хууль дээрээ шимтгэлийнх нь асуудлыг Засгийн газар яг оруулж ирсэн юмаараа оруулж ирээд тэгээд энэ дээрээ

нэг мөр цэгцэлчих л ёстой байсан гэж хараад байгаа байхгүй юу. Тэгэхгүйгээр одоо ингээд 2-ын хооронд 3-ын дунд ингээд хаячихдаг. Одоо тэгээд дахиад нэг салбар хариуцсан нэг хууль дээр нь яг одоо НДШ-ийн асуудал нь тэндээ яваад байдаг. Тэгээд тэр нь онцгой он энд онцгой ажил хийдэг гэдгээр нь юм уу тусгай төрийн тусгай алба гэдгээр нь гэдэг юм уу ингээд явчихаараа энэ бол ер нь тийм сайн зүйл биш, энэ бол ухралт гэж харж байгаа.

Тийм учраас Засгийн газрын зүгээс бол энэ байр сууриа илэрхийлсэн энэ ийм юугаа ашиглаад энэ удаад бол Улсын Их Хурлаар шийдүүлчих ёстой байсан гэдгийг хэлмээр байна. Тэгээд энэ тал дээр дахин байр суурийг тань тодруулъя аа.

Б.Пүрэвдорж: Булгантуяа ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Булгантуяа: Өмнө нь бид нар 2023 онд бараг 8 орчим салбаруудын өөрөө өөрсдийнхөө хуулиар энэ тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалын харилцааг зохицуулдаг байсныг болиулсан юм. Дипломат байгууллагуудаас авхуулаад л зарим байгууллагууд бол тус тусдаа хуулиараа ер нь бол нийгмийн хамгаалал, нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийнхээ асуудлыг шийддэг байсан. Монгол Улс нийгмийн даатгалын сан гэдэг нэг л сантай. Тэр санд бид нар бүгдээрээ төлөөд тэндээс өнөөдөр тэтгэвэр авч байгаа 500 мянган хүний тэтгэврийг тавьж байна. Манай цэргийн тэтгэврийнхэн гэхэд шимтгэл хэдийгээр төлдөггүй ч гэсэн түүнийг нь тэтгэвэрт гарахад нь улсын төсвөөс үүнийг нь хуулиараа угаасаа олгоод явж байгаа. Тэгээд яах вэ өнгөрсөн удаа 3 салбарынхыг хийж чадаагүй. Шүүх, прокурор ҮХЦ гурав. Тэгээд энэ удаа Засгийн газраас шүүх прокурор 2-ыг Нийгмийн даатгалын ерөнхий хуулиараа нийгмийн даатгалын санд нэгэнт шимтгэл төлж байгаа юм чинь энэ хуулиараа зохицуулагдах ёстой гээд уг нь оруулж ирсэн.

Б.Пүрэвдорж: Нэмээд нэг минутаар хариулъя.

Х.Булгантуяа: Тэгээд би нөгөө процессын хувьд яаралтайгаар өргөн барихдаа тухайн байгууллагуудаас нь саналыг нь аваагүй явсан гээд тэгээд одоо энэ хуулийн процессынх нь хувьд эргэн эргүүлэн татъя гэдэг ийм шийдвэрийг Засгийн газар хуралдаад гаргасан юм байна аа гэж би ойлгосон. Одоо наадах чинь юу үүсчхээд байна вэ гэхээр нөгөө манай хуулиуд маань хоорондоо зөрчилтэй болчхоод байгаа юм. Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар бол НДШ төлсөн л бол нийгмийн даатгалын санд төлсөн бол энэ хуулиараа тэтгэврийн асуудлууд нь зохицуулах ёстой байгаад байдаг. Гэтэл нөгөө хуулиараа үгүй ээ, манайх өөрийнхөө шүүхийн прокурорын хуулиараа асуудлаа шийднэ гээд ингээд өнгөрсөн жил гэхэд 8 орчим шүүгчтэй бас нэг 7, 8 аль аль салбараас нь хүмүүсийн асуудлыг шүүх дээр очиж тэтгэврийнх нь асуудлыг шийдэж байгаа. Аль хуулиар нь шийдэх юм бэ гэдэг ийм байдлаар шийдэж байгаа юм. Тэгэхээр Засгийн газраас өөрснөө эс үгүй бол энэ байгууллагуудынх одоо өөрсдийнх нь хуулиар явна аа гэх юм бол Нийгмийн даатгалын ерөнхий хууль дээрээ бүүр өөрчлөлт оруулах ёстой. Улсын Их Хурал зөрчилтэй хуулиудтай Монгол Улс яваад байж болохгүй байна энэ асуудал дээр.

Б.Пүрэвдорж: Би Аубакир сайддаа нэг үг хэлчихье. Тэгэхээр өчигдөр Оюу Толгойн асуудал явсан. АН-ын бүлэг бол софр дээр нэмэх нь 3 буюу 6.5-аас дээшгүй хүүтэй байх ёстой гэдэг ийм зарчим дээр хатуу байсан. Тэгэхдээ бас мэдээж амжилт гарлаа. Тэгэхлээр энэ жил болгон бас ноогдол ашгаа авах тухай асуудал яригдсан. Тэгэх дээр энэ ноогдол ашиг 2025, 2026 оны ноогдол ашгаа урьдчилж авах талаар нэлээн хичээх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл энэ 7 сард, 8 сард ноогдол

ашгаа урьдчилж аваад, тэгээд энэ 8 юм уу 9 сард төсвийн тодотгол явах нь гарцаагүй. Тийм нөхцөл байдал руу оччихсон байж байгаа. Тэгэх дээр энийг заавал баялгийн сан руу оруулахгүйгээр нийгмийн даатгалын сан руу оруулаад тэр нэг энэ хуулийн дагуу хэрэгтэй байгаа тэр 3 их наяд төгрөг, түүн дотроо ахмадын тэтгэврийг 1.5 сая болгох тэр ажлуудыг хийх хэрэгтэй. Энийг шахаж ажиллах хэрэгтэй. Салбарын сайдын хувьд. Энэ үүдэн дээр чинь бүтэн хэдэн сар ахмадууд бүтэн жил ахмадууд одоо эсэргүүцэл зарлаад суугаад байдаг. Нэг нь ч гарч уулздаггүй, албан тушаалтнууд уулздаггүй ийм нөхцөл байдалтай байна.

Хоёрдугаарт нь энэ малчны тухай хуулийн хэрэгжилт энэ дээр Бат-Эрдэнэ дэд дарга бол нэлээн сайн амжилттай ажиллаад энэ сонсголыг хийгээд, энэ малчдад хэрэгтэй ийм шийдвэрүүдийг гаргаад Засгийн газар луу чиглэл өгсөн байгаа. Тэгээд энэ малчны нийгмийн даатгалын нөхөн төлөх тухай энэ асуудлыг 2024 оны 5 сард батлагдсан тэр хуулиараа хэрэгжүүлэхгүй, сонгуулиар санал авчхаад тэгээд мартаад явчихсан. Энэ асуудлуудыгаа шийдвэрлэх ийм ажлуудыг зайлшгүй хийх ёстой шүү гэж хэлмээр байна аа.

Ингээд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг 17 цагаас явуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

16.30 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Дөрөв.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл */Хөдөө аж ахуйн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан,* ***анхны хэлэлцүүлэг****/*

Б.Пүрэвдорж: Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна аа. Индэрт урьж байна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Мандхай нараас 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ХАА-н тухай хуулийн төслийн тогтвортой ХАА гэсэн 12 дугаар зүйл. Тогтвортой ХАА-г хөгжүүлэх зорилгоор улсын хэмжээнд дунд хугацааны хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх нь зүйтэй гэж өргөн мэдүүлсэн.

Дээрх зохицуулалттай нийцүүлж ХАА-н тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах саналыг гаргаж, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжсэн болно оо.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2026 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулах үед Улсын Их Хурлын гишүүд уг хуулийн төсөл нь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6 дахь хэсэгт заасан төсөл нь Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал дүгнэлтээ холбогдох байнгын хороонд ирүүлсэн байна гэснийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тул хуралдаан даргалагч уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр Эдийн засгийн байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд буцаасан болно оо.

Эдийн засгийн байнгын хороо 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдөр хуралдаанаараа дээрх асуудлын төслийг хэлэлцэж Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.5 дахь хэсгийг баримтлан хэлэлцэж, санал дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.42.5 дахь хэсгийг баримтлан Хөгжлийн бодлого, төлөвлөлт удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг дахин явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үед үе шаттай нэгтгэн явуулах гэсэн горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно оо.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Б.Пүрэвдорж: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Гомбын Ганбаатар гишүүн алга байна. Баатаржавын Мөнхсоёл гишүүн алга байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн алга байна, Жудагийн Баярмаа гишүүн алга байна. Батын Батбаатар гишүүн алга байна, Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууна аа.

М.Мандхай: Одоо ингээд ХАА-н тухай хуультай дагалдаж орж ирж байгаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн асуудлыг хэлэлцэж байгаа юмаа. Яагаад энэ хуульд энэ хөгжлийн бодлого ХАА-н хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх ёстой юм бэ гэхлээр энэ ХАА-н салбарын хөгжил нь өөрөө энэ үйлдвэрлэлийн биологийн өөрөө урт ийм мөчлөгтэй, улирлын чанартай, мэдээж стратегийн ач холбогдолтой ийм чухал салбар байгаа. Мэдээж Засгийн газрын одоо энэ үйл ажиллагаа төрийн бодлогын ийм залгамж чанар, тогтвортой хэрэгжилтийг ийм хангах шаардлагатай байгаа. Тэгээд яг үндсэндээ бол энэ манай Засгийн газар солигдох бүрд эсвэл сонгууль сонгуулиас сонгуулийн хооронд солигдож ирж байгаатай холбоотойгоор энэ үндсэн ХАА-н тэргүүлэх чиглэл төсөв, байгууллагын бүтэц дандаа өөрчлөгдөж ирсэн. Гэтэл ХАА-н үйлдвэрлэлийн энэ үр дүн бол өөрөө 1-4 жилийн ийм мөчлөгт хамааралтай бол биш. Хамгийн багадаа энэ өөрөө 10-20 жил зарцуулж байж үр дүнгээ харуулдаг ийм онцлогтой салбар байгаа юмаа.

Олон улсад яг үндсэндээ ингээд хараад үзэх юм бол жишээлбэл Хятад улс хөрш орон энэ ХАА-ынхаа хөгжлийн бодлого төлөвлөлт энэ зорилтоо бол 2050 он хүртэл 2018 онд баталсан стратегиа 2050 он хүртэл хэрэгжүүлэх ийм зорилт дэвшүүлсэн байна. Нидерланд улс гэхэд л ялгаа байхгүй 30 жилийн ийм алсын хараатай, Шинэ Зеланд улс мөн ялгаа байхгүй 30 жил, Австрали улс яг урт хугацааны ийм хөгжлийн хөтөлбөртэй ингээд явж ирсэн. Тийм учраас энэ одоо энэ үндсэндээ энэ Засгийн газрын 5 жилийн үндсэн чиглэл, энэ бусад одоо энэ 4 жилийн хөгжлийн хөтөлбөр гэдгийг үл хамаараад залгамж халаатай, тогтвортой өөрөө хэрэгждэг ийм зорилтот хөтөлбөр явах ёстой гэдэг үүднээс.

2 дугаарт өөрөө бас энэ эдийн засгийн тулгуур салбар уул уурхайгаас ангид болж хөгжих ийм шаардлага хэрэгцээтэй байгаа учраас хөгжлийн бодлого төлөвлөлтийн түүний удирдлагын тухай хуульд ХАА-н ийм хөгжлийн зорилтот хөтөлбөртэй байх ёстой юмаа гэж үзсэн учраас энэ хөтөлбөрийг оруулж ирсэн юм аа. Тэгээд энэ хуулийн ач холбогдлыг яг ХАА-н салбар салбарыг хөгжүүлэхийн төлөө ажиллаж дуугарч байгаа гишүүд маань дэмжиж ажиллаасай гэсэн ийм хүсэлтэй байгаа учраас үг хэлж байна аа.

Б.Пүрэвдорж: Мандхай гишүүн үг хэллээ. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн манай одоо идэвхтэй өдөржингөө хуралдаа суудаг Мөнгөнцог гишүүнд баяр хүргэе. Ганхүлэг. Асуулт асууна аа.

М.Ганхүлэг: Баярлалаа дарга аа. Өнөөдөр асуултынхаа өмнө нэг товчхон бас өнөөдөр 7 сарын 1-ний өдөр байгаа. 18 жилийн өмнөх 7 сарын 1-ний өдрийг бид мартах учиргүй ээ. Иргэдийнхээ бас итгэлийг алдвал нийгмийн нэлээн эмх замбараагүй байдлууд бий болдог. Иргэд гудамд гардаг тодорхой одоо бас энэ засаглалын хямралд ордгийн жишээг бас харуулсан ийм өдөр байсан. Үүнийг бас бид нар мартаж болохгүй. Сургамж бас их авах ёстой. Энэ бас ардчилсан парламентын гишүүдийн хувьд иргэд олон нийтийнхээ дуу хоолойг бид нар энд хэлж, хэлэлцэж асуудлаа нээлттэйгээр ярьж хэлж чадахгүй бол төлөөллийн энэ байдлаа бид нар хадгалж чадахгүй бол ийм хүртэл нөхцөл байдал бас үүсэж болдгийг харуулсан ийм өдөр тохиож байсан. Тэгэхээр цаашдаа ч гэсэндээ бид бүхэн хүчээр асуудлыг шийдэхээс илүүтэй эвлэлдэж нэгдэж, ил тод байж нээлттэй одоо энэ ардчилсан парламент, ардчилсан засаглалаа хамгаалахын төлөө явах ёстой. Үүнийг сануулсан өдөр юм шүү гэдгийг би үгийнхээ эхэнд хэлье гэж бодож байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль процессын хувьд алдаагаа зассан байх гэж бодож байна. Ямар байдлаар зассан бэ гэдгийг би түрүүлээд асууя. Бид бүхэн энэхүү хуулийн 6.5-д энэ дунд хугацаа буюу 10 жилээр нийтдээ 8 зорилтот хөтөлбөрийг баталж явуулна аа гэдэг ийм хуулийн төслийг хуулийг бол баталсан байгаа. Үүн дээр нэмээд ХАА-н чиглэлийн буюу ХАА-н салбарыг 10 жилээр төлөвлөөд явдаг ийм хөтөлбөр лүү очих гэж байна аа. Гэсэн хэдий боловчиг дунд хугацааны хөтөлбөрийн маань энэ одоо 8 зорилт хөтөлбөр бүгдээрээ өнөөдрийг хүртэл бас батлагдаагүй байгаа. Үүний учир шалтгаан юу байгаа вэ? Алсын хараа 2050 гэж бид бүхэн том зорилт тавиад урт хугацаандаа, дунд хугацаандаа бол ингээд 10, 10 жилээр голлох салбарууддаа үндсэндээ төлөвлөөд ажиллаж байна. Тэр салбарууд дотроо эдийн засгийн тэргүүлэх салбар болсон ХАА-гаа оруулж ирж байгаа нь зөв өө. За ингээд үндсэндээ энэ хууль батлагдлаа ч хэрэгжихгүй байгаа, энэ зорилт хөтөлбөрүүдээ бид нар баталж чадахгүй байгаагаас болоод дараа дараагийн асуудлууд үүснэ ээ. Тийм учраас бусад хөтөлбөрүүд яагаад батлагдаагүй байгаа, батлагдсан хөтөлбөрүүд маань ямар үр дүнтэй байгаа, ХАА-н зорилтот хөтөлбөрийн хувьд бас одоо ямар процессоор энэхүү хөтөлбөр батлагдаж, хэрэгжилтийг хэн хянаж явах вэ гэдгийг дэлгэрүүлж асууя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр 2008 оны 7 сарын 1-ний энэ аюулт өдөр энэ хүний эрхийг зөрчсөн асар том зөрчил гарсан. Үүнийг сануулж хэлж байгаа МАН-ын гишүүн Мөнгөнцогийн Ганхүлэг танд маш их баярлалаа. Тэгээд манай Ганхүлэг бол хуралдаа яс суудаг, хүмүүсийн санаа бодлыг сайн сонсдог гишүүн байгаа. Танд ажлын амжилт хүсье ээ.

2 дугаарт нь одоо нэг хүн асуулт асуугаад үүний дараагаар санал хураалт явагдана. Тамгын газрынхан болон Их Хурлын гишүүдийн туслах, зөвлөх нар гишүүддээ зар хүргээрэй. Яг 17 цагтаа тэрнээс өмнө гишүүд бүрдчихвэл санал хураалтаа явуулъя. Асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ Их Хурлын дэд дарга хариулна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа. ХАА-н тухай хуулийг хэрэгжүүлэх явцад батлуулах явцад ажлын хэсгийн хүрээнд ярьж байгаад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль дотор хэрэгжүүлэх зайлшгүй ХАА-н ингээд бодлогыг оруулах нь бол зүйтэй юм байна аа гээд үндсэндээ бол Монголын ХАА маань бас нэлээн задгайдуу явж байгаа. Бид ажлын хэсэг дээр ч ярьсан одоо бас чуулган дээр ч ярьсан. Яг дээрээсээ гарсан энэ бодлого төлөвлөлт бол доошоогоо бүүр хөрсөн дээрээ хүртлээ бол энэ босоо тогтолцоогоор бол явж чадахгүй байгаа. Өнөөдрийг хүртэл ХАА хөгжиж чадахгүй байгаагийн одоо төлөвшиж чадахгүй байгаа, тогтворжиж чадахгүй байгаагийн нэг нь бол энэ бодлого бол бас алдагдаад байна аа гэж үзээд Бодлого төлөвлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулахаар болсон.

Тэгээд бодлого Улсын Их Хурлын тухай хуульд дагалдаж байгаа хууль нь хамтдаа хэлэлцэх ёстой, хэлэлцэгдэх ёстой. Тэгээд бид нөгөө Их Хурлынхаа товд чуулганы хуралдааны товд энэ асуудал маань оролгүй техникийн алдаанаас болоод оролгүй өнжчихсөн байгаа учир энийгээ татаж буцаад алдаагаа засаад Төрийн байгуулалтын байнгын юу Эдийн засгийн байнгын хороогоор бол ороод асуудал маань ороод тэнд дэмжигдээд буцаад Байгаль орчин, ХАА-н байнгын хороон дээр орж хэлэлцэгдээд ингээд чуулган руу бол орж ирж байгаа юмаа гэж.

Үндсэндээ бол Дэгийн тухай хуулийнхаа дагуу алдаагаа засаад буцаад орж ирж байна.

Б.Пүрэвдорж: Мандхай гишүүн нэмж хариулъя.

М.Мандхай: Бат-Эрдэнэ даргын яг хэлсэн дээр нэмээд ер нь энэ 20 оны энэ хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн гол энэ 8 энэ хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 8 төрлийг заасан байгаа. Гэхдээ харамсалтай нь энэ ХАА-д тусад нь ерөөсөө дурдаагүй. Энэ 6.5.3 дээр эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөрт нэгтгэсэн нэгтгэж орсон байгаа. Гэхдээ харамсалтай нь энэ Алсын хараа 2050-д хэрэгжүүлэх зорилгоор энэ ганцхан заалт орж ирсэн. Гэхдээ энэ эдийн засаг дэд бүтцийн зорилтот хөтөлбөрт ХАА бол өөрөө бусад олон салбар болон уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтэцтэй хамт орж ирсэн байгаа. Тэгэхээр энэ тухайн салбарт зориулсан энэ тусгайлсан хөтөлбөр, зорилт, шалгуур үзүүлэлт, санхүүжилтийн тодорхой хуваарилалт өөрөө бас сул ийм байж ирсэн юмаа.

Тэгэхээр энэ өргөн хүрээтэй ийм баримт бичиг дээр нэг салбарын онцлогийг уусаж энэ хэрэгжиж чадахгүй хяналт хариуцлага нь тодорхойгүй явж ирсэн байгаа учраас энэ салбар...

Б.Пүрэвдорж: Дахиад нэмж нэг минутаар хариулъя.

М.Мандхай: Тэгэхээр энэ нөгөө гол энэ өргөн цар хүрээтэй байгаа энэ баримт бичиг дээр нэг салбарын онцлог илүү нөгөө ерөнхий ийм уусаж хэрэгжилтийн хяналт өөрөө энэ хариуцлага нь өөрөө тодорхойгүй байгаа учраас ерөнхийдөө ийм нэгтгэсэн бодлогын баримт бичгүүдийг нийтлэг нь өөрөө ийм сул хэрэгжилттэй явж байгаа гэж бас харж байгаа. Тийм учраас одоо яг энэ ХАА-н салбарыг тусгайлан эдийн засгийн гол тулгуур салбар 2 дахь уул уурхайн дараа орж байгаа салбар байгаа учраас урт хугацаанд Засгийн газар болон энэ сонгуулийн мөчлөг тааруулсан биш эсрэгээрээ энэ урт хугацаанд өөрөө хөгжиж явах хөгжлийн зорилтот хөтөлбөртэй одоо байя гэж байгаа.

Тэгээд хууль дээрээ болохоор үндсэндээ бол төрийн захиргааны төв байгууллага үндсэн гол хөтөлбөрийг гаргаад, аймаг сумдууд болохоор яг энэ хөгжлийнхөө хөтөлбөртэй байя. Ингээд нийтдээ энэ ХАА-н үндсэн гол бодлого зорилтот хөтөлбөр нэгдсэн одоо...

Б.Пүрэвдорж: Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Засгийн газраас төлөөлөл байгаа юм болов уу. Яах вэ миний хувьд энэ ХАА-н салбарыг онцолж оруулж ирж байгааг бол 2 гараа өргөөд дэмжиж байгаа. Гол нь нөгөө бид нар ингээд зорилтот хөтөлбөртэй байна аа гээд хуульдаа оруулчихдаг. Өмнөх 8 дээр нэмэрлээд одоо ингээд 9 зорилтот хөтөлбөртэй болох нь л дээ. Гэхдээ өмнөх 8-ын 2, 3-хан нь л зорилтот хөтөлбөрөө баталчихсан байгаа байхгүй юу. Бусад нь одоо болтол батлагдаагүй. Батлагдаагүй байгаа тэр шалтгаан нөхцөл нь юу вэ? Үүний хойноос энэ ХАА-н зорилтот хөтөлбөр маань орох вий дээ. Тэгээд ер нь одоо энийгээ бид нар батлахгүй болохоор чинь хэрэгжилтийг нь хянах дараа дараагийн юмнууд чинь ингээд бүгдээрээ л болохгүй болоод явж байна шүү дээ. Тэгэхээр яг хэд нь батлагдсан байгаа юм, хэд нь батлагдахгүй батлагдаагүй

байгаа юм. Яагаад энийгээ ер нь бид нар оруулж ирж ярихгүй байна вэ гэдгийг асуугаад байгаа юмаа. Тийм 8 хөтөлбөрөөс.

Б.Пүрэвдорж: Үг хэллээ. Одоо асуултад Улсын Их Хурлын дэд дарга, ажлын хэсгийн ахлагч Жадамбын Бат-Эрдэнэ хариулна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь бол 8 зорилт хөтөлбөр байгаа шүү дээ. Би бол одоо эндээс яг хэд нь батлагдсан гэдгийг нь бол хэлж мэдэхгүй байна. Бид өөрсдөө хариуцлагаа Засгийн газраасаа ер нь нэхэж сурах хэрэгтэй. Бид өнөөдөр Ерөнхий сайдаа томилсон. Мөрийн хөтөлбөрийг нь баталж өгсөн. Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг нь батлаад явуулсан. Засгийн газар Ерөнхий сайд өөрсдийнхөө салбар салбарынхаа сайд нарыг өөрөө дагуулаад орж ирсэн. Бидэнд танилцуулаад бид бол одоо ингээд ажиллах бололцоог нь олгосон шүү дээ. Тэгэхээр энэ салбар болгон дээр хүний хөгжилтэй холбоотой асуудал, нийгмийн бодлого хөгжилтэй холбоотой асуудал, эдийн засагтай холбоотой асуудал, дэд бүтэцтэй холбоотой энэ зорилтот хөтөлбөрүүдийг Засгийн газар боловсруулах ёстой шүү.

Одоо өнөөдөр бид нар анхны нээлттэй сонсголыг хийсэн. Хяналтын сонсгол хийсэн. Энэ хяналтын сонсгол бол ХАА-н малчны тухай хууль дээр хийсэн. Тэрэнтэй адилхан ийм сонсголуудыг хийж дахиад нэхэх л асуу...

Б.Пүрэвдорж: Одоо Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууна аа.

С.Эрдэнэболд: Хөгжлийн бодлого төлөвлөлт. Бид нар ингээд жил болгон төлөвлөөд яваад байгаа. 4 жилийн Засгийн газрын хөтөлбөр байгаа. Дунд хугацаа, урт хугацааны стратеги зорилтууд байдаг. Тэр яг одоо бодит байдал дээр яг энэ хөгжлийн бодлого маань, төлөвлөлт маань яг эдийн засгийг чадавхжуулах, ядуурлыг бууруулах, амьжиргааг ахиулахад чиглэсэн зүйл дээр бас тэр болгон хангалттай хэрэгжиж чадахгүй байгаад байгаа юм. Яах вэ уул уурхай тойрсон томоохон дуулиан шуугианыг улс төрийн гаргалгааг гаргалаа л гэж бид нар сурталчлаад байгаа болохоос биш яг энэ эдийн засгийн тогтвортой хөгжил рүүгээ чиглэсэн төлөвлөлттэй энэ бодлого явж байна уу гэвэл маруухан.

Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газрын үед олон мега төсөл хөтөлбөрүүд ярьж байсан. Одоо хаана байна? Зарим нь шинэ гарсан дарга нар нь зогсоогоод, зарим нь шүүх рүү шилжээд ингээд явж байгаа. Цаана нь болохлоороо энд улс төрчид гэхээсээ илүүтэйгээр Монгол Улсын хөгжлийн тэр бодлогууд тэр боломжууд алдагдсан боломж болж үлдэж байгаа нэг.

Хоёрдугаарт ХАА-н зорилтот хөтөлбөр гээд сая Ганхүлэг гишүүн бас зөв хэлж байна л даа. Өмнөх хөтөлбөрүүд ямар шатандаа хэрэгжсэн юм, яагаад нэмэлт зорилт зайлшгүй тодорхойлох тэр нь ингээд энэ хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлтийн хэмжээнд шаардлагатай байгаад байгаа гэсэн зүйлүүд судалгаа бол хангалттай биш байгаад байгаа юм. Жишээ татъя. Төвийн бүс Дархан, Сэлэнгэ, Төв аймаг, 118469 мянган км квадрат нутаг дэвсгэртэй. Сэлэнгэ аймгийн үлэмж хэсэг Дархан-Уул аймгийн тодорхой хэсэг Төв аймгийн хойд талын сумдууд газар тариалангийн бүс нутаг ХАА-н салбар гээд бид нар ярьдаг. Тэгэхдээ өнөөдөр ингээд гоё гоё үгтэй уриа лоозон, зорилтот хөтөлбөрүүд, чамин ганган презентац тавигддаг ч гэсэн, цагаан буйдан дээр дарга нар суугаад гаднаас хүн уриад, гоё гоё юм ярьдаг ч гэсэн яг бодит хөрсөн дээрээ

асар олон асуудлууд байдаг. Ялангуяа малчид, тариаланчид хоёрын хоорондын газар нутгийн маргаан, нэгнийхээ тариалангийн талбайн хашааг нь буулгасан гэх маргаан, тэнд нь мал бэлчсэн гэх маргаан, малыг нь буудсан тухай хэргийн түвшинд орчихсон. Бид нарын энэ цаасан дээр байгаа зорилтууд амьдрал дээр бодитой хэрэгжиж чадаж байна уу, үгүй юү? Тэгээд газар тариалангийнхаа салбарыг өөрсдөө гэдсээ хүүлж байгаа юм шиг хорлогчин бодлогыг явуулдаг. Тодорхой цөөн тооны хүмүүсийн лоббинд автдаг. Тэр ХАА-н зорилт хөтөлбөр маань яг юу байх юм. Ямар зайлшгүй шаардлагатай юм бэ?

Ер нь энэ олон гаргасан уриа лоозон болсон бодлогууд маань хэрэгжилтийн ямар шатандаа явж байгаа юм бэ гэдгийг бид нар тэр болгон ярихгүй байна л даа. Тэгээд ингээд хэлэлцэж байгаа асуудал нь, хариулж байгаа нь ч тэр, асууж байгаа нь ч тэр ерөнхийдөө формалдаж өнгөрөөд байна аа. Тийм учраас ер нь ингээд бид нар нэг морь унасан толгойгүй хүн шиг, хүн харахад ажил хийгээд байгаа царай гаргадаг, хөрсөн дээр нь бодлого нь явдаггүй, нөгөө малчид, тариаланчид, нөгөө одоо ХАА-н салбарт ажиллаж байгаа хүмүүс нь улам л эдийн засгийн ч тэр, шударга ёсны ч тэр сүүдэрт хүнд байдалтай байгаад байдаг ийм асуудлууд байгаа юм аа. Тийм учраас ажлын хэсгийн дарга аа, энэ асуултад хариулж өгөөч.

2 асуулт. 1 дүгээрт зайлшгүй энэ одоо Хөгжлийн зорилт хөтөлбөрийг гаргах үндэслэл нь юу вэ нэг.

Хоёрдугаарт нь өмнө гаргасан энэ хөтөлбөрүүд яагаад зайлшгүй энэ хөгжлийн тухай хууль дээр Бодлого төлөвлөлтийн хууль дээр шинээр ийм зохицуулалт болох шаардлага гарч байгаа. Тэрэн дээр тодорхой үндэслэлтэй дүгнэлт, дүн шинжилгээ хийгдсэн үү? Ийм асуултууд асууя.

Б.Пүрэвдорж: Гишүүдийг наашаа чуулганы танхимдаа орж ирэхийг урьж байна. Одоогоор нэг 40 орчим гишүүн байна. 2 Байнгын хороо яг 5 цаг гэж байхад хуралдаанаа хойшлуулаад гишүүдээ наашаа оруулна шүү. Ингээд дөрөвхөн санал хураалттай байгаа. Хариултыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын дэд дарга Жадамбын Бат-Эрдэнэ хариулна аа.

Ж.Бат-Эрдэнэ: Эрдэнэболд гишүүн та ерөнхийдөө бол хариулт буцаад өөрөө хэлчихлээ дээ. ХАА-н үйлдвэрлэл нь хөгждөггүй, хүн дээрээ очдоггүй, өртөг нэмэгддэггүй, тодорхой Засгийн газрын бодлого, төрийн бодлого нь очдоггүй ийм үндэслэл байгаа учир л энэ бодлогыг ийшээ оруулъя гэж. ХАА хөгжсөн хүн рүүгээ очдог байх, МАА, газар тариалан энэ нь өөрийн гэсэн өртөгтэй байх. Өөрийн гэсэн өртгөө нөхдөг байх, ашигтай байх. Одоо өнөөдөр малчид олдохгүй болчхоод л хот руу нүүгээд явчихлаа. Малчин залуу малчин алга болчихлоо л гээд байна шүү дээ. Энэ чинь өөрөө ашигтай байсан бол тэнд ингээд нүүгээд хамаг эдийн засгаа бизнесээ хаячхаад явах хүн гэж байх уу. Энэ мал аж ахуй чинь өөрөө ашигтай байж байж тэнд чинь энэ бизнес өөрөө ашигтай боллоо гээд тэнд малчин хүн тогтоно шүү дээ. Тэгээд энэ ХАА чинь би бол ХАА-г бол зэрлэг ХАА гэж тодорхойлдог юм хувь хүнийхээ хувьд. Бид одоо гадагшаа гараад л явахаараа л гайхамшигтай сайхан ХАА тэр одоо ХАА-н бүтээгдэхүүний боловсруулалт эзэндээ очиж байгаа өртөг нэмэгдүүлж байгаа, өртгийн үйлдвэрлэл сүлжээ гээд ингээд үйлдвэрлэлийн сүлжээ гээд бүх л зүйлийг нь бид нар сайхан хараад л байдаг шүү дээ. Энэ чинь өнөөдөр бууж байгаа зүйл байгаа юм уу. Малчдадаа очиж байгаа зүйл байгаа юм уу, хэрэглэгчдэдээ очиж байгаа зүйл байгаа юм уу, малчдадаа наалдаж байгаа зүйл байгаа юм уу. Энэ бодлого чинь дутагдаад байна.

Би яг тантай адилхан л хариулт хэлэх гээд байна шүү дээ. Асуулт асуух гээд байна. Яагаад гэхээр энийг хэн хариулах вэ гэхээр Засгийн газар хариулах ёстой байхгүй юу. Бидний эндээс гаргасан мөрийн хөтөлбөр, бидний эндээс гаргасан Засгийн газрын хөтөлбөрийг хэн хэрэгжүүлэх ёстой юм. Энд байж байгаа саяын миний дурдсан 8 зорилтот хөтөлбөрийг хэн хэрэгжүүлэх ёстой юм. Засгийн газар хэрэгжүүлэх ёстой шүү дээ. Одоо энэ 8 хөтөлбөр дотор чинь яг ХАА-н бид нарын хаягдаад байгаа ХАА-н бодлого энэ дотор байхгүй байгаа болохоор энэ бодлого нь өөрөө эдийн засгийн болоод дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр гэдэг дотор орчхоод байгаа юмаа Эрдэнэболд гишүүн ээ.

Тийм болохоор энэнээс нь таслаад цаашдаа энэ асуудал нь явдаг байх, ХАА дээр очдог байх, наалддаг байх. Тэгээд эдийн засгийн хүрээнд тодорхой хэмжээний салбар болж хөгжих тийм үү одоо сая Мандхай гишүүн хэллээ шүү дээ. Уул уурхайн салбарын ард дээр очиж байх ийм салбар болгохын тулд бид нар босоо ийм том бодлого хэрэгждэг байхын тулд өнөөдөр зорилтот хөтөлбөртэй, энэ дотор ХАА-н хөгжлийн зорилтот хөтөлбөр гэдэг зүйлийг оруулъя гэдгээр одоо ингээд зориг шулуудаад оруулж ирж байгаа шүү.

Ер нь бол энэ хуулийг анх Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг бид нар анх гаргаж байхдаа урьд өмнө би бас баталж байсан хүн. Дахиж энд гар хүрэхгүй гэж тохирч байсан л даа. Энэ дотор бүх эдийн засгийн бүх зүйлүүд орчихсон гэж үзэж байсан юм. Тухайн үед бол ХАА-н миний тусад нь байх ёстой гэдэг санал хэдийгээр гаргаж байсан ч гэсэн энэ эдийн засаг гэдэг дотор орчихсон гээд явсан. Өнөөдөр яг ХАА-н хуулийг баталж байгаа явцад бол зайлшгүй өөрийн гэсэн хөтөлбөртэй байх нь зүйтэй юмаа гэдэг утгаас өнөөдөр энэ хуулийг бол оруулж ирж байгаа юм шүү гэж танд хэлье ээ. Баярлалаа.

Б.Пүрэвдорж: Эдийн засгийн байнгын хороо нэлээн олон асуудалтай байгаа байх. Гишүүн түр завсарлуулаад наашаа гишүүдээ оруулаарай. Тэгэх дээр энэ хооронд гишүүдийг цуглах хооронд би нэг зүйлийг хэлье гэж бодож байна.

Гашуун сухайтын нүүрс тээврийн асуудал бол нэлээн асуудал болоод байна аа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын сайд Энхбаяр байна. Таны доор төрийн өмчийн нүүрсний компаниуд байж байгаа. Аж үйлдвэрийн уул уурхайн сайд Дамдинням тэр биржийн асуудлыг хариуцаж байгаа. Зам тээврийн сайд Дэлгэрсайхан замынхаа асуудал хариуцаж байгаа. Та 3 нэг ярилцаад энэ одоо биржээр нүүрс зарахлаар Монгол талынх нь худалдагч нь нүүрснийхээ тээврийн асуудлыг хариуцдаг болж байгаа. Тэгээд үүнээс шалтгаалаад хамгийн бага зардлаар тэд нар тээврээ хийдэг. Үүний дээрээс нь одоо маш их шатахууны дизель түлшний үнэ нэмэгдчихсэн байж байхад үнэ нь өсдөггүй, үүнээс нь болоод нэг хэсэг гэр бүлийг авч явж байгаа тэр хүмүүсийн бизнес нэлээн доголдолд ороод байна аа. Тэгэх дээр Монгол Улс бол тэр нүүрсээ зарж ашиг олох ёстой. Бусдаар бол юу байдаг юм тэр тээврийн жолооч нарын тээврээс ашиг олж ерөөсөө болохгүй шүү дээ. Тийм учраас энэ нүүрс тээвэр болон бирж 2-ыг салгах хэрэгтэй байна. Ингэснээр юу байдаг юм худалдагч тал нь зөвхөн амнаасаа нүүрсээ зараад ашгаа олоод явдаг, цаашаа одоо экспортыг нь худалдаа тээврийг нь худалдан авагч талтай тохироод цаашаа явдаг одоо тээврийнх нь, үнийнхээ асуудлыг шийдвэрлэдэг ингэх тохиолдолд тээвэр хийж байгаа тэр компаниуд цаад талын худалдан авагч талтайгаа нүүрснийхээ тээврийн үнийг өсгөх ийм боломжийг өөрсдөө бий болгох боломжтой болох байхгүй юу даа.

Тийм учраас 3 сайд энэ дээр ярилцаж байгаад асуудлаа тодорхой шийдэл гаргаж, тэр тээвэрчдийн асуудлыг эерэгээр шийдэхийн төлөө ажиллаарай гэж шаардаж байна аа.

Эдийн засгийн байнгын хороо яасан бэ? Хурал зохион байгуулахынхан энэ байнгын хорооны хуралдааныг дэлгэц дээр гарга даа. АН-ынхнаас энэ тодорхой хугацаа гарч байна. Энийг тохиолдуулан үг хэлэх хүн байна уу. Ард түмэндээ хандаж. Дэг зөрчих юм уу за за.

Энэ чинь Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулиудын талаар ярилцъя. Тэгээд энэ нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32.1-д хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно.

32.3-д хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатанд байгаагаас үл шалтгаалан хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно оо гэж тус тус заасан. Үүний дагуу хууль санаачлагчаас хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Их Хурлын дарга Сандагийн Бямбацогт Танаа. 2026 оны 7 сарын 1. Засгийн газрын 1/74 албан бичиг. Хуулийн төслийг татан авах тухай.

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасны дагуу татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2026 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Учрал гэсэн байна аа.

Тэмдэглэл дээр нь бол татан авах тухай тогтов гээд Засгийн газар Хэрэг эрхлэх газрын бичигтэй байна. Нийгмийн даатгалын хуулийн дагаж орж ирсэн Шүүхийн тухай хууль болон Прокурорын тухай хууль. Буцааж татаж байгаа Засгийн газар нь өөрөө.

Засгийн газар 2026 оны 6 дугаар сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг татан авсанд тооцлоо.

Зочин танилцуулъя. Дархан-Уул аймгийн Хонгор сумын ЕБС-ийн 1986 оны 8-ын А, 8-ын Б ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа болон Төрийн

ордонтой танилцаж байна аа. Та бүхэнд ажлын өндөр амжилтыг Улсын Их Хурлын гишүүдийн нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ.

Байнгын хорооны санал хураалт дуусаж байна уу? Мэдээ аваад хэлээдхээрэй.

С.Бямбацогт: Эдийн засгийн байнгын хороо хуралдаж байгаа. Одоо дуусах гэж байна. Дуусахаар санал хураалт явна. Тэнд нэг 20-иод гишүүн сууж байгаа. Тэрийг дуусангуут санал хураалтаа явуулна. Гишүүдээ түр хүлээж байгаарай. Гишүүд үүдээр байгаа гишүүдийг танхимдаа урьж байна. Эдийн засгийн байнгын хорооны хурал дууссан. Санал хураалтаа явуулъя хэдүүлээ. Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалтууд явуулна. Санал хураалтууд явуулахын өмнө ирц бүртгэлийн санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Хуруугаа уншуулсан уу гишүүд ээ. Ирц бүртгэлийн санал хураалт.

110 гишүүнээс 72 гишүүн чуулганы танхимд санал хураалтад оролцож байна.

Бат-Амгалан гишүүн татгалзсанаас алга байна. Батсүмбэрэл гишүүн, Батсуурь гишүүд ирцэд байгаа юм байна. Бат-Амгалан гишүүн ирцэд байгаа юм байна. 35 гишүүн бусад 35 гишүүнийг чуулганы хуралдааны танхимд хүрэлцэн ирэхийг урья. Санал хураалт явуулъя.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

110 гишүүнээс 76 буюу 69 гишүүний санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүллээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай асуудлаар гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж 2 гишүүн үг хэлж болно. Зарчмын зөрүүтэй 4 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийн 7 дахь заалт буюу 21 дүгээр зүйлийн 21.29 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.29.Сүүлийн таван жилийн дотор нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр

бүртгүүлсэн таваас ихгүй ажилтантай ажил олгогчийн гурав хүртэл ажилтны ажил олгогчийн төлөх энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан нийгмийн даатгалын шимтгэлээс 36 сар хүртэлх хугацаанд, хэрэв ажилтан хөгжлийн бэрхшээлтэй бол 60 сар хүртэлх хугацаанд чөлөөлж болно. Хэрэв ажил олгогч 5 ажилтантай бол 3 ажилтны, 4 ажилтантай бол 2 ажилтны, 2 ба 3 ажилтантай бол 1 ажилтны ажил олгогчийн төлөх шимтгэлээс чөлөөлөгдөнө. Энэ шимтгэлийн чөлөөлөлтөд даатгуулагч зөвхөн нэг удаа хамрагдана.

Тайлбар: Сүүлийн таван жил гэдгийг ажил олгогч шимтгэлээс чөлөөлөгдөх хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргасан сараас өмнөх 60 сарыг ойлгоно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

110 гишүүнээс 79 гишүүн буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал.

1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

119-өөс 79 буюу 71 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг 2 дугаар зүйл болгож доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.8 дахь заалтад заасан суурь тэтгэвэрт шаардагдах хөрөнгийг 2027 оны улсын төсөвт тусгана.” Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

110-аас 84 буюу 76 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

1.Нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тэтгэвэр тогтоолгосон 60 насанд хүрсэн эрэгтэй тэтгэвэр авагчид, 55 насанд хүрсэн эмэгтэй тэтгэвэр авагчид олгох суурь тэтгэвэр (C_T)-ийн хэмжээг тооцоход баримтлах үзүүлэлтийг Засгийн газраас тогтоохдоо Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг харгалзах бөгөөд суурь тэтгэврийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгоно. Санал гаргасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо.

110-аас 83 гишүүний 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Өнөөдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэх асуудал дуусаж өндөрлөлөө. Ингээд чуулган нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон 83 гишүүндээ их баярлалаа. Улсын Их Хурлын Тамгын газар, хуулийн төсөл эх барьж байгаа зөвлөхүүддээ их баярлалаа. Сайхан амарцгаагаарай.

17.40 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА